



УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ-ХОЁРДУГААР ҮЕ ШАТ

**“ДАМБАДАРЖАА ДЭД ТӨВ”-ИЙН 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 0004103 /

2023



“УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ-ХОЁРДУГААР ҮЕ ШАТ

**“ДАМБАДАРЖАА ДЭД ТӨВ БАРИХ ТӨСЛИЙН 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 0004103 /

Хянасан :

**Нийслэлийн Байгаль орчны газар, Хүрээлэн буй
орчин, байгалийн нөөцийн хэлтсийн мэргэжилтэн**

/ Ж.Батзолбоо /

Биелэлтийг тайлагнасан:

**Улаанбаатар хотын гэр хорооллыг
хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих
хөтөлбөр төслийн зохицуулагч**

/ Д.Авирмэд /

**Улаанбаатар хотын гэр хорооллыг
хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих
хөтөлбөр төслийн байгаль орчны мэргэжилтэн**

/ З.Мөнх-Оргил /

Боловсруулсан:

“Од Дайнамик” ХХК-ийн захирал

/ Д.Даваамаа /

**Улаанбаатар хот
2023 он**



ГАРЧИГ

1	ОРШИЛ.....	1
2	ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 2	2
2.1	2023 оны барилгын ажлын хэрэгжилтийн талаарх товч танилцуулга	6
2.1.1	DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц	6
2.1.2	DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.	10
3	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
3.1.1	DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц	17
3.1.2	DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.	29
3.	ОРЧНЫ ТОХИЖИЛТ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	42
3.1.3	DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц	42
3.1.4	DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.	42
4	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	43
4.1.1	DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц	43
4.1.2	DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.	45
5	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	46
5.1.1	DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц	46
7.1.1	DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.	53
6	ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	58
6.1.1	DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.	58
6.1.2	DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц	61
7	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	62
7.1.1	DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.	62
7.1.2	DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц	67
8	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	69



9	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	70
10	ДҮГНЭЛТ.....	72
11	Хавсралт материал.....	73
11.1.1	DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.	73
	ХАВСРАЛТ I. Аж ахуйн нэгжийн гэрчилгээ	73
	ХАВСРАЛТ II. Тусгай зөвшөөрөл	74
	ХАВСРАЛТ III. ХАБЭА-н дотоод журам	76
	ХАВСРАЛТ IV. Хог хаягдлын гэрээ	91
	ХАВСРАЛТ V. Лабораторийн шинжилгээний үр дүнгүүд	96
11.1.2	DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц	104



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2-1. Төслийн байршил	2
Хүснэгт 2-2. Төслийн хүрээнд хийгдэх ажлын тоо хэмжээ.....	2
Хүснэгт 2-3. Дамбадаржаа дэд төвд 2023 оны барилгын ажлын явц	3
Хүснэгт 2-4 Төслийн төлөвлөлт	10
Хүснэгт 3-1. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	17
Хүснэгт 3-2. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	29
Хүснэгт 3-1. DAFPE үерийн хамгаалалтын орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	42
Хүснэгт 4-1. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	43
Хүснэгт 5-1. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	46
Хүснэгт 6-1. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	61
Хүснэгт 7-1 Байгаль орчны хяналт, шинжилгээний төлөвлөгөө.....	62
Хүснэгт 7-2. Агаарын чанарын хяналт, шинжилгээний үр дүн.....	62
Хүснэгт 7-3 . Хөрсний чанарын хяналт, шинжилгээний үр дүн.....	63
Хүснэгт 7-4 Хөрсний химийн задлан шинжилгээний дүн	64
Хүснэгт 7-5. Хөрсний механик бүрэлдэхүүний шинжилгээний дүн	64
Хүснэгт 7-6 Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн.....	65
Хүснэгт 7-7. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн	65
Хүснэгт 7-8. Усны чанарын хяналт, шинжилгээний үр дүн	66
Хүснэгт 7-9. Усны хүнд металлын шинжилгээний дүн	66
Хүснэгт 7-10. Усны шинжилгээний эрүүл ахуйн шинжилгээний дүн.....	66
Хүснэгт 7-11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	67
Хүснэгт 9-1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт.....	70

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2-1. 2023 оны барилгын ажилын явц.....	3
Зураг 2-2. Төслийн талбайн байршил	4
Зураг 2-3. Дамбадаржаа дэд төвийн засаг захиргааны хил хязгаар.....	5
Зураг 2-4 . Төслийн талбайн районы агаар, сансрын зураг.....	7
Зураг 2-5. Үерийн хамгаалалт, авто зам дагуух ус зайлуулах байгууламжийн ажлын үеийн фото зураг	8
Зураг 2-6 2023 оны 10-р сарын 10 өдөр.....	9
Зураг 2-7. Дамбадаржаа дэд төвийн авто замын төлөвлөлт	10
Зураг 2-8. Дамбадаржаа дэд төвийн цэвэр усны эх үүсвэр.....	11
Зураг 2-9. Дамбадаржаа дэд төвд шинээр барьж байгуулах ус дамжуулах шугам хоолойн трасс	12
Зураг 2-10. Ариутгах татуургын төлөвлөлт	12



**“Дамбадаржаа дэд төв барих төсөл” төслийн 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль
орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Зураг 2-11. Дулаан хангамж төлөвлөлт	13
Зураг 2-12 Авто зам барих талбайн хөрс хуулалт хийгдсэн	16
Зураг 3-1. Хог хаягдлыг ангилах ялгах хогийн сав	27
Зураг 3-2. Ариун цэврийн байгууламжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж буй фото зураг	27
Зураг 3-3. Ажил явагдах үед хамгаалалтын тор байршуулж ажилласан Барилга угсралтын ажлын үед ажилчид хамгаалалтын малгайг байнга өмссөн байдал.....	27
Зураг 3-4.....	28
Зураг 3-1. Техникийн нөхөн сэргээлт хийсэн	42
Зураг 3-2. Техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэж буй байдал.....	43
Зураг 5-1. Төслийн талбайд байршуулсан галын хор, сарааны зураг	49
Зураг 5-2. Газар шорооны ажил явагдаж буй цэгийг тойруулан хамгаалалтын хашлага татсан байдал.....	49
Зураг 5-3. Төслийн мэдээллийн самбар	50
Зураг 7-1. Таних тэмдэг.....	50
Зураг 7-2. Ажилчдын хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын хувцас хэрэглэл	50
Зураг 7-3. Барилгын угсралт, газар шорооны ажлын үед таних тэмдэг, тэмдэглэгээ, хаалт зэргийг байршуулсан байдал.....	51
Зураг 7-4. Барилгын газар шорооны ухлагын ажлын үед болон угсарсаны дараах худгийн таг суурилуулахаас өмнө эрсдэлээс хамгаалсан байдал.....	51
Зураг 7-5. ХАБЭА-н чиглэлээр гүйцэтгэсэн ажлууд	52
Зураг 7-6. Осол эрсдэлээс хамгаалах хашлага тэмдэг тэмдэглэгээ хийсэн байдал	56
Зураг 7-7. ХХАА-ны заавчарчилгаа сургалт явуурж буй байдал.....	57
Зураг 6-1. Ажилчидын кемпийн зохион байгуулалт, хог хаягдлын цэг байршуулсан байдал.	60
Зураг 7-1 Хөрсний чанарын хяналтын, дээжлэлт.....	64
Зураг 7-2. Хөрсний дээж авч буй фото зураг	68
Зураг 7-3. Агаарын сорьц авч фото зураг	68



ТОВЧИЛСОН ҮГС

АХБ - Азийн Хөгжлийн Банк

БОАЖЯ - Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам

БОМТ - Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө

БОМТБ - Т Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөний биелэлтийн тайлан

БОХШХ - Байгаль Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

БОНЕУ - Байгаль Орчны Нөлөөллийн Ерөнхий Үнэлгээ

БОННУ - Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ

БОХХ - Байгаль Орчны Хөндлөнгийн Хяналт

БДТ - Баянхошуу Дэд Төв

ЕХО - Европын Хөрөнгө Оруулалтын Банк

ЗДХ - Зөвшөөрөгдөх Дээд Хэмжээ

МУИС - Монгол Улсын Их Сургууль

НЗДТГ - Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар

НБОГ - Нийслэлийн байгаль орчны газар

НӨ - Нөлөөлөлд Өртөх

СБДТ - Сэлбэ, Баянхошуу дэд төв

СЭС - Сошио Энвайронментал Сервис

СДТ - Сэлбэ Дэд Төв

ГХХХОДХ - Гэр Хорооллыг Хөгжүүлэх, Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Хөтөлбөр

ТУН - Төслийн Удирдах Нэгж



1 ОРШИЛ

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага баримт бичгийн дагуу хотын гэр хорооллын дэд бүтэц, нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулах, тогтвортой хөгжүүлэхэд чиглэгдсэн арван жилийн хугацаатай хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл юм.

Энэхүү хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүн, нөлөөлөл нь Улаанбаатар хотын амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах явдал юм. Энэхүү хөтөлбөрийн гол зорьж буй үр дүн нь Улаанбаатар хотын гэр хорооллыг тогтвортой, олон талыг хамардаг, сайн-бүтэцтэй болгон хөгжүүлэх явдал юм. Хөтөлбөрөөс гарах үр дүн нь:

- (i) Эдийн засгийн боломжууд, байшин барилга барих, хөдөлмөр эрхлэх боломж олгох, байгаль орчинд үүсэх нөлөө, тухайлбал: хөрс, агаарын бохирдолтой холбогдох нөлөөг багасган дэд төвүүдийг хөгжил сайтай бүс болгох
- (ii) Ус хангамж, бохир ус, дүүргийн халаалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг санхүүгийн хувьд бие даасан өндөр чанартай үйлчилгээ үзүүлдэг болгох зорилгоор орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах боломжтой болгох;
- (iii) Зах зээлийн таатай орчин, зохистой хууль эрх зүйн орчинд үндэслэсэн оновчтой, олон нийтээр идэвхтэй оролцдог өсөлтөд чиглэсэн хот төлөвлөлтийн тогтолцоог бий болгох зэрэг юм.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн 2-р үе шатанд Дамбадаржаа дэд төв төслийн хүрээнд автозам, инженерийн шугам сүлжээ, үерийн байгууламж, хүүхдийн цэцэрлэг, Дулааны станц зэрэг барилга, байгууламжийг барих ажлыг хийхээр төлөвлөсөн байна.

2023 оны 10 дугаар сарын байдлаар Дамбадаржаа дэд төв төсөлд хамаарагдах нийт 7 төслийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалт явагдахаас. 2 төслийн барилга байгууламжын ажил буюу үерийн далан байгуулах ажил 2022 оны 8-р сараас эхэлж хийгдэж байгаа бол бусад Дари 1-2 багц нь 2023 оны 4-р сараас эхэлж байрилгын ажил явагдаж байна бусад төслийн барилга байгууламжийн ажил тендерийн шатанд байна. Дамбадаржаа дэд төв төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) 2020 онд хийгдэж, БОАЖЯ-аар батлагдсан. энэхүү төрийн захиргааны байгууллагаас батлагдсан төлөвлөгөөний дагуу Баянхошуу ниймгийн барилга байгууламжын ерөнхий БОМТ 2021 оны биелэлт, хэрэгжилтийн тайланг 2019 оны 10-р сарын 29-ны өдөр Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам (БОНХЯ)-ны сайдын баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” А-618 дагуу боловсруулав.

2 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн 2-р үе шатанд хамрагдах Дамбадаржаа дэд төв нь Сүхбаатар дүүргийн 16, 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 70.7 га талбайг хамран оршино. Төсөлд хамрагдах нутаг дэвсгэр нь одоогийн байдлаар 1145 өрхийн 4,236 оршин суугчтай ба 1 га талбайд 69 хүн ногдож байгаа хэдий ч уг төсөл хэрэгжсэнээр 2030 онд 1973 өрх, 7105 хүн 17 блоконд оршин сууж 1 га-д ногдох хүн амын тоо 165 болон өсөн нэмэгдэх төлөвтэй байна. Төслийн талбайн байршил, засаг захиргааны хуваарийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2-1. Төслийн байршил

№	Дүүрэг	Хамрах хороод	Координатын солбицол
1	Сүхбаатар дүүрэг	16, 17, 18-р хороод	47° 58' 51.9" 106° 55' 56.1"

Төслийн хүрээнд хийхээр төлөвлөгдсөн дэд бүтцийг хөгжүүлэх ажлын тоо хэмжээг доорх хүснэгтэд чиглэл тус бүрээр нь хураангуйлан үзүүлэв.

Хүснэгт 2-2. Төслийн хүрээнд хийгдэх ажлын тоо хэмжээ

Багцын дугаар	Дэд бүтцийн ажлууд	Ажлын тоо хэмжээ
DARI-1	Авто зам	Урт: 1063 м, өргөн: 7 м
	Дулаан хангамж	<ul style="list-style-type: none"> Дулааны шугам Урт= 1141 м, диаметр (Ф150~350мм) Дулааны дэд станц: 3 байрлалд
	Цэвэр усан хангамж	Цэвэр усны шугам: Ф150~300мм, урт= 1044 м
	Ариутгах татуургын сүлжээ	Бохирын шугам: Ф200~300мм, урт= 1817 м
	Дренажийн шугам	Дренажийн шугам: урт 863 м, өргөн 1-1.5 м
DARI-2	Авто зам	Урт: 1526 м, өргөн: 7 м
	Дулаан хангамж	<ul style="list-style-type: none"> Дулааны шугам Урт= 1453 м, диаметр (Ф150~350мм) Дулааны дэд станц: 4 байрлалд
	Цэвэр усан хангамж	Цэвэр усны шугам: Ф150~300мм, урт= 1360 м
	Ариутгах татуургын сүлжээ	Бохирын шугам: D200~300мм, урт= 1214 м
	Дренажийн шугам	Дренажийн шугам: урт 522 м, өргөн 1-1.5 м
DAEC	Цахилгаан хангамж	Цахилгааны кабель шугам: урт= 3038 м, хүчин чадал 160-240 кВ.мм 10/0.4кВ хүчин чадалтай хаалттай дэд станц (ХТП) шинээр байгуулах: 6 байрлалд Хаалттай хуваарилах байгууламж шинээр байгуулах: хүчин чадал 10кВ, 1 байрлалд.
	Холбоо харилцаа	Холбооны төвийн барилга: 1 байрлалд, 1 давхар барилга Шилэн кабель: урт=3 км Холбооны шугам: урт 6.3 км, диаметр: 110мм
ASKG-DA	Хүүхдийн цэцэрлэг	792м ² талбай бүхий 2 давхар барилга, 150 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай
DAFPE	Үерийн хамгаалалт	Дамбадаржаагийн үерийн сувгийг тохижуулах: Урт 895м, өргөн 1.0-1.5м; Ус нэвтрүүлэх туннель, урт: 540м, өргөн 300-500 мм


Хүснэгт 2-3. Дамбадаржаа дэд төвд 2023 оны барилгын ажлын явц

Гэрээний дугаар	Бүтээн байгуулалтын ажлын тодорхойлолт	Байршил	2023 оны барилгын ажлын явц	2023 оны барилгын ажил үргэлжлэх хугацаа	Барилгын ажлын явцын хувь	2023 онд барилгын ажил гүйцэтгэх байгууллагын нэр
ASKG-DA	Хүүхдийн цэцэрлэгийн барилга	СБД-ийн 16,17-р хороод	Барилгын ажил эхлээгүй	18 сар	0	-
DARI-1	Авто зам, дэд бүтцийн шугам сүлжээ байгуулах ажлууд, 1-р хэсэг	СБД-ийн 16,17-р хороод		18 сар	15	Янчэнг Шингүо Констракшн Инженейринг ХХК
DARI-2	Авто зам, дэд бүтцийн шугам сүлжээ байгуулах ажлууд, 2-р хэсэг	СБД-ийн 16,17-р хороод		18 сар	10	
DAEC	Цахилгаан, холбоо, интернэтийн шугам сүлжээ татах ажлууд	СБД-ийн 16,17-р хороод		6 сар	0	Монхас ХХК
DAFPE	Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажил	СБД-ийн 16,17-р хороод	2023 оны 8-р сард барилгын ажил эхэлсэн.	6 сар	100	JV of Newconstruction LLC and Tenuunkhas Sar LLC
DHAP	Дамбадаржаа 63мб дулааны станц барих	ЧД-ийн 19-р хороод	Барилгын ажил эхлээгүй	24 сар	0	-


Зураг 2-1. 2023 оны барилгын ажилын явц



Зураг 2-2. Төслийн талбайн байршил



Зураг 2-3. Дамбадаржаа дэд төвийн засаг захиргааны хил хязгаар



2.1 2023 оны барилгын ажлын хэрэгжилтийн талаарх товч танилцуулга

2.1.1 DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц

Төслийн нэр:

- “Дамбадаржаа дэд төв барих төсөл”

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

- “Нью констракшн” ХХК
 - Улсын бүртгэлийн дугаар: 9011033077
 - Регистрийн дугаар: 2574799

Аж ахуй нэгжийн албан ёсны хаяг, утас

- Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, бага тойруу, 18/1, 5 тоот
- Утас: 77328186

Үйл ажиллагааны чиглэл

- Гадаад худалдаа

Төслийн товч танилцуулга, хүчин чадал

- Уг төсөл нь “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн 2-р үе шатанд хамрагдах Дамбадаржаа дэд төв төслийн дэд бүтцийн нэг багц ажил болно.
- Дамбадаржаа дэд төв төслийн хүрээнд хийгдэж буй үерийн хамгаалалт барих DAFPE- дэд бүтцийн ажил юм.
- Тус үерийн хамгаалалтын ажил нь Сүхбаатар дүүргийн 16, 17-р хороонд хэрэгжинэ.
- Төслийн бэлтгэл ажил 5 сараас эхлэн, 6 сард талбай дээр ажил эхэлсэн ба одоогоор 90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.
- Үерээс хамгаалах сувгийн даланг бетондож бэхжүүлэх- урт 895 м, өргөн 1.0-1.5 м
- Эко хавтангаар явган хүний зам тавих: 895 м
- Ус нэвтрүүлэх туннел барих: урт 540 м, өргөн 0.3- 0.5 м

Төслийн байршил

“Дамбадаржаа дэд төв барих” төслийн DAFPE гэрээний дугаар бүхий Дамбадаржаагийн үерээс хамгаалах сувгийг тохижуулах төслийн байршил нь СБД-ийн 16, 17-р хорооны нутагт байрлана.

- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: М-48-10

Зураг 2-4 . Төслийн талбайн районы агаар, сансрын зураг



2.1.1.1 Төслийн үе шатны хэрэгжилтийн талаарх товч танилцуулга

“Нью констракшн” ХХК нь дээрх төслийн DAFPE гэрээний дугаар бүхий Дамбадаржаагийн үерээс хамгаалах сувгийг тохижуулах багцад ажлыг ажиллах гэрээний дагуу хийж гүйцэтгэж байна. Тус ажлыг “Нью констракшн” ХХК нь 2022 оны 6 сарын 1-нээс эхэлсэн ба одоогоор 100 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Зураг 2-5. Үерийн хамгаалалт, авто зам дагуух ус зайлуулах байгууламжийн ажлын үеийн фото зураг



Зураг 2-6 2023 оны 10-р сарын 10 өдөр



2.1.2 DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.

2.1.2.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Аж ахуй нэгжийн нэр:	“Янчен Шингуо Констракшн Инженеринг” ХХК
Бүртгэлтэй хаяг:	Жансу муж Янчен хот Ше Ян дүүрэг Хадэ суурин Наньюан 2-27-2
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар:	Улсын бүртгэлийн дугаар: 320924000086159 Регистрийн дугаар: 9935924
Хуулийн этгээд:	Шү Чангуо
Аж ахуй нэгжийн хэлбэр:	ХХК /хувь хүн хөрөнгө оруулсан /
Гэрчилгээний ангилал:	Хот төлөвлөлт, шугам сүлжээ дулааны дэд төв 3-р зэрэг, Авто замын байгууламж, замын гэрэлтүүлэг, замын бетон хийцийн тусгай гүйцэтгэл 3-р зэрэг
Үйл ажиллагааны чиглэл:	Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.
Дэд төвийн байршил	Төслийн хүрээнд явагдах салбар шугамын холболтын ажлууд нь Сүхбаатар дүүргийн 17,18-р хороодыг хамарна.


Хүснэгт 2-4 Төслийн төлөвлөлт

Гэрээний дугаар	Дэд бүтцийн ажлууд	Ажлын тоо хэмжээ
DARI-1	Авто зам	1063м урттай, 7м өргөн
	Дулаан хангамж	Дулааны шугам- 1141м, диаметр (Ф150-350мм) Дулааны дэд станц 3нь байрлалд
	Цэвэр ус хангамж	Цэвэр усны шугам: Ф150~300мм, урт= 1044 м
	Ариутгах татуургын сүлжээ	Бохирын шугам: Ф200~300мм, урт= 1817 м
	Дренажийн шугам	Дренажийн шугам: урт 863 м, өргөн 1-1.5 м
DARI-2	Авто зам	1526м урттай, 7м өргөн
	Дулаан хангамж	Дулааны шугам Урт= 1453 м, диаметр (Ф150~350мм) Дулааны дэд станц: 4 байрлалд
	Цэвэр ус хангамж	Цэвэр усны шугам: Ф150~300мм, урт= 1360 м
	Ариутгах татуургын сүлжээ	Бохирын шугам: D200~300мм, урт= 1214 м
	Дренажийн шугам	Дренажийн шугам: урт 522 м, өргөн 1-1.5 м

2.1.2.2 Авто замын төлөвлөлт


Дамбадаржаа дэд төвийн авто замын сүлжээг сайжруулах зураг төслийн хүрээнд Дамбадаржаа дэд төвд Сэлбэ голын орчмоос Дамбадаржаалин хийд, Дамбадаржаагийн гүүр хүртэлх чиглэлд 2.589 км урттай хатуу хучилттай авто замыг шинээр барьж байгуулахаар төлөвлөсөн. Уг зам нь 6 хэсгээс бүрдэх бөгөөд тус дэд төвийн эргэн тойрон дахь төв замуудыг дэд төв доторх замын сүлжээтэй холбосон 3 уулзвартай байна. Авто замын өргөн нь 7 метр 2 эгнээ нийт 2.589 км урт байхаар төлөвлөгдсөн.

Зураг 2-7. Дамбадаржаа дэд төвийн авто замын төлөвлөлт



№	Багцын дугаар	Урт (м)	Өргөн (м)
1	DARI-1	1063	7.0
2	DARI-2	1526	7.0
Нийт		2589	


Дамбадаржаа дэд төвд шинээр тавих авто замын трасс



2.1.2.3 Цэвэр усан хангамжын төлөвлөлт


Дамбадаржаа дэд төвийн цэвэр усан хангамж нь гүний усны эх үүсвэртэй бөгөөд 1-р үе шатны хүрээнд Сэлбэ дэд төвд барьж ашиглалтад оруулсан 1500 м³ багтаамжтай Хайлааст усан сан ба 1000 м³ багтаамжтай Дамбадаржаа усан сангаас тус тус хангагдана. Эдгээр усан сангуудыг Гачууртын эх үүсвэрээс хангах ба "Гачууртын эх үүсвэр" нь Улаанбаатар хотын иргэд, ялангуяа гэр хорооллын 390,000, орон сууцны 43,500 оршин суугчдыг цэвэр аюулгүй усаар хангагдах боломжийг бүрдүүлсэн томоохон эх үүсвэр юм. Энэ эх үүсвэр нь Улаанбаатараас 26 километрийн зайд, зүүн хэсэгт, Баянзүрх дүүргийн 20 дугаар хороонд оршдог

Зураг 2-8. Дамбадаржаа дэд төвийн цэвэр усны эх үүсвэр



Дамбадаржаа дэд төвд шинээр барьж байгуулахаар төлөвлөж буй 150-300 мм-ийн диаметр бүхий цэвэр ус дамжуулах шугам хоолойн трассыг доорх зурагт хөх өнгийн шугамаар тэмдэглэн үзүүлэв.

Зураг 2-9. Дамбадаржаа дэд төвд шинээр барьж байгуулах ус дамжуулах шугам хоолойн трасс



2.1.2.4 Ариутгах татуургын сүлжээний төлөвлөлт

Тус төслийн 1-р үе шатны хүрээнд ариутгах татуургын сүлжээг Сэлбэ дэд төв хүртэл татсан бөгөөд 2-р үе шатны хүрээнд Сэлбэ дэд төвөөс цаашлуулан Дамбадаржаа дэд төв хүртэл шинээр 3.03 км урт бохир ус дамжуулах шугамыг барьж байгуулахаар төлөвлөсөн байна. Дамбадаржаа дэд төвөөс өдөрт 1540 м³ бохир ус цугларах ба түүнийг 200-300 мм-ийн диаметртэй уг шугамаар УБ хотын ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлнэ.

Зураг 2-10. Ариутгах татуургын төлөвлөлт



2.1.2.5 Дулаан хангамжын төлөвлөлт

Шинээр баригдах дулааны станцаас Дамбадаржаа дэд төв рүү 150-350 мм-ийн голчтой, 2594 метр урт дулааны шугам хоолойг татах бөгөөд уг хоолойгоор 24.51 Гкал дулаанаар дэд төвийг хангана. Мөн 7 байрлалд дулааны дэд станцыг барьж байгуулна. Доорх зурагт Дамбадаржаа дэд төвд барьж байгуулах дулааны шугамын трассыг улаан өнгийн шугамаар тэмдэглэн үзүүлэв

Зураг 2-11. Дулаан хангамж төлөвлөлт



2.1.2.6 Барилгын ажлын явц

Дамба-2, 5 -р хэсгийн цэвэр бохир усны шугмын газар шорооны ажил, угсралт хийгдсэн





Зураг 2-12 Авто зам барих талбайн хөрс хуулалт хийгдсэн



3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1.1 DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц

Хүснэгт 3-1. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
1. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ					
1	Газар шорооны ажилд нийт 0.16 га талбайн газрын гадарга, хэвлий өртөж эвдрэл үүсэх	- Бохир хөрсийг хусаж зайлуулах, талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ хийх ажилд өртөж эвдэрсэн талбайн 50%-д буюу 0.08 га талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц анхны төрх байдлаас нь илүү сайжруулсан орчны тохижилт хийх	- Төслийн газар шорооны ажлын дараа ухсан нүхээ буцаан шороогоор дүүргэлт хийж, хөрсөө нягтаршуулан техникийн нөхөн сэргээлт хийсэн.	Үйл ажиллагааны зардал	
2	Газар шорооны ажлаас 1910 м ³ хаягдал шороон материал үүсэх	- 405 м ³ хэмжээтэй шороон материалыг нөхөн дүүргэлт, тохижилтын аж илд ашиглаж, 1505 м ³ хэмжээтэй хаягдал шороон материалыг Цагаан давааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг Сүхбаатар дүүргийн хот тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө. - Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана.	- Газар шорооны ажлаас гарсан шороог буцаан далангийн тохижилт нөхөн сэргээлт зам талбайг тэгшлэх ажилд ашигласан. - Хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнаж байсан.	Үйл ажиллагааны зардал	
3	Газрын гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орох	- Бохир хөрсийг хусаж зайлуулах, талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ хийх газар шорооны ажлуудаас бий болох шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох - Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрлаж байсан цэгт талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх	- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэв.	Үйл ажиллагааны зардал	
Нийт			-	-	
2. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ					

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
4	Газар шорооны ажил, талбайн тэгшилгээ хийх, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас 83.46 кг/жил хэмжээтэй тоосжилт үүсэж агаар орчныг бохирдуулах	<ul style="list-style-type: none"> - Бохир хөрсийг хусаж зайлуулах, талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ хийх газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд хуурай өдрүүдэд м² талбайд 2-4 л нормын дагуу тогтмол усалгааг хийх - Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох - Хүчтэй салхи шуургатай үед хөрсний овоолгоос тоосжилт үүсэхээс сэргийлж усалгаа хийх - Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх 	<ul style="list-style-type: none"> - Төслийн газар шорооны ажил явагдаж буй үед хуурайшилттай өдрүүдэд тохиогүй. 	Үйл ажиллагааны зардал	
5	Барилгын ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал, бохирдуулагч бодисууд ялгарч агаар орчныг бохирдуулах	<ul style="list-style-type: none"> - Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх - Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх 	<ul style="list-style-type: none"> - Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх 	Үйл ажиллагааны зардал	
6	Цемент, элс зэрэг нунтаг бодисууд, мод төмрийн үртэс, хаягдал материалууд салхинд хийсэж орчны агаарт бохирдол үүсгэж болзошгүй	<ul style="list-style-type: none"> - Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын /MNS 5013:2009, MNS5014:2009/ дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах 	<ul style="list-style-type: none"> - Төсөлд ашиглаж буй тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулан тэнцсэн гэсэн бичгийг тус бүр авсан. 	Үйл ажиллагааны зардал	
7	Цемент, элс зэрэг нунтаг бодисууд, мод төмрийн үртэс, хаягдал материалууд салхинд хийсэж орчны агаарт бохирдол үүсгэж болзошгүй	<ul style="list-style-type: none"> - Барилгын ажил явагдаж буй цэгүүдэд талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж байх - Дулааны эх үүсвэр гаргах буюу хаягдал материалыг устгах зорилгоор шатамхай материалыг ил талбайд шатаахыг хориглоно 	<ul style="list-style-type: none"> - Төслийн ажил явагдаж буй цэгүүдэд талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол хугацаанд зайлуулсан. - Шатамхай материалыг шатаагаагүй болно. 	Барилгын ажлын төсөвт багтсан	
Нийт					-
3. ФИЗИК ОРЧИНД СӨРӨГ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ					

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
8	Газар шорооны ажил, барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах ажлуудаас дуу чимээ үүсэх	<ul style="list-style-type: none"> - Зам барилга ба барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэг, оношилгоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох - Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх - Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих 	<ul style="list-style-type: none"> - Төсөлд ашиглаж буй тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулан тэнцсэн гэсэн бичгийг тус бүр авсан. - Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд хийж гүйцэтгэж байсан. - Бид орчны хяналт шинжилгээний хүрээнд дуу шуугианы хэмжилт хийж шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав. 	<p>Үйл ажиллагааны зардал</p> <p>ОХШХ-т тусгасан</p>	
9	Барилгын болон ахуйн хог хаягдлыг зүй зохистойгоор цуглуулж, зайлуулаагүйгээс физик орчны бохирдол үүсгэх	<ul style="list-style-type: none"> - Сүхбаатар дүүргийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж, түүнд хаягдал шороон материал, ахуйн ба барилгын хог хаягдлыг зайлуулах цэг ба тээвэрлэх автомашины улсын дугаарыг тодорхой зааж өгөх - Барилгын ажил явагдаж буй цэгүүдэд хогийн хаягдлын цэг тогтоож, зориулалтын хогийн сав байрлуулах - Барилгын түр кемп тус бүрд хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж, тэмдэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Төслийн үйл ажиллагааны явцад гарсан ахуйн болон техникийн хог хаягдлыг ангилан Цагаан даваа хогийн цэгт кг-аар бодон тушаадаг. - Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгах зориулалттай хогийн сав байршуулсан (Зураг-3) 	<p>Үйл ажиллагааны зардал</p>	
10	Барилгын болон ахуйн хог хаягдлыг зүй зохистойгоор цуглуулж, зайлуулаагүйгээс физик орчны бохирдол үүсгэх	<ul style="list-style-type: none"> - Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох - Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих - Барилгын түр кемпүүдээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах - Барилгын ажил дууссаны дараа хог хаягдлыг цуглуулж зайлуулах, талбайн цэвэрлэгээг бүрэн гүйцэд хийж хяналтын инженерт хүлээлгэн өгөх 	<ul style="list-style-type: none"> - Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглож нийт ажилчдад талбайн инженер зааварчилгаа өгч ажиллаж байсан. - Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналтыг талбайн инженер тавьж ажиллаж байсан. - Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулсан. 	<p>Үйл ажиллагааны зардал</p>	
Нийт					-
4. ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ					

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
11	Хүний хайхрамжгүй үйл ажиллагаанаас гадаргын усны бохирдол үүсгэж, усны чанарт нөлөөлөх	- “Усны тухай хууль”-ийн заалтуудыг дагаж мөрдөх, Сэлбэ гол, Дамбадаржаагийн үерээс хамгаалах суваг дагуу усны хамгаалалт бүс тогтоож, уг бүсэд машин тэрэг угаах, түлш цэнэглэх, хог хаяхыг хатуу хориглох	- “Усны тухай хууль”-ийн заалтуудыг дагаж мөрдөж, Сэлбэ гол, Дамбадаржаагийн үерээс хамгаалах суваг дагуу усны хамгаалалт бүс тогтоож, уг бүсэд машин тэрэг угаах, түлш цэнэглэх, хог хаяхыг хатуу хориглож нийт ажилчдад талбайн инженер анхааруулан ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардал	
12	Хог хаягдлыг зүй зохистой зайлуулаагүйгээс гадаргын усны бохирдол үүсэх	- Үерээс хамгаалах сувагт хуримтлагдсан хог хаягдал, хагшаас цэвэрлэх, бохирдсон хөрсийг хусаж зайлуулах ажлын үед цугларсан хаягдал материалыг нэн даруй буюу тухайн өдөрт нь багтаан ачиж зайлуулах - Хог хаягдал буюу хаягдал шороон материалын түр овоолгыг үерт автахаргүй газарт сонгож түр байрлуулах - Энэхүү төлөвлөгөөний 3-р хэсэгт заагдсан хог хаягдлын менежментийн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	- Төслөөс гарах хог хаягдлыг тухай бүр цуглуулан өдөрт нь зайлуулж байсан тул гадаргын усанд сөрөг нөлөөгүй. - Төслийн хүрээнд хог хаягдлын менежментийн арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.	Барилгын ажлын төсөвт багтсан	
13	Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч, хур борооны усаар зөөгдөх буюу хөрсөнд нэвчих байдлаар гадаргын болон газрын доорх усны бохирдол үүсгэх	- Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх - Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх - Шатах тослох материал асгарсан үед, хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах	- Газар шорооны ажлын талбайд гарах машин, техник хэрэгсэлд тогтмол үзлэг оношилгоо хамруулсан. Тээврийн хэрэгслийн оношилгоонд хамрагдсан баримтыг хавсаргав.	Үйл ажиллагааны зардал	
14	Барилгын болон ахуйн зориулалтаар багавтар хэмжээний ус ашиглах	- Үйл ажиллагаанд шаардагдах усны эх үүсвэр, хэрэглээг тогтоож, ус ашиглалтын гэрээ байгуулж ажиллах - Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажиллах	- Унд, ахуйн усыг ойролцоох гүний худгаас зөврөөр авч ашигласан. - Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд унд, ахуйн уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд өгсөн (хавсралтаар хавсаргав).	Үйл ажиллагааны зардал	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
15	Шингэн хаягдал, ариун цэврийн байгууламжид хуримтлагдсан ялгадас зэрэг нь хөрсөнд нэвчиж газрын доорх усны найрлага, чанарт нөлөөлж болзошгүй.	<ul style="list-style-type: none"> - Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх - Барилгын түр кемпийн ариун цэврийн байгууламжид бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх 	<ul style="list-style-type: none"> - Барилгын түр кемпээс үүссэн шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байсан. - Ариун цэврийн байгууламжид ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж байсан (Зураг-4). 	Үйл ажиллагааны зардал	
Нийт					
5. ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ					
16	Машин тэрэг, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрс суларч доройтох, хөрсний элэгдэл үүсэж болзошгүй	<ul style="list-style-type: none"> - Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж хүнд даацын машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах - Барилгын ажил дуусах үед хөрс суларч доройтон, хөрсний элэгдэл үүссэн газруудад нөхөн сэргээлт, орчны тохижилт хийх 	<ul style="list-style-type: none"> - Машин техникийн хөдөлгөөнийг тогтсон маршрутаар зорчуулж, тэмдэг тэмдэглэгээ тавьж ажилласан. - Газар шорооны ажлын үед гарсан шороог буцаан зам талбайг засах, орчны тохижилтын ажилд ашигласан. 	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	
17	Газар шорооны ажлын улмаас 0.16га талбайн хөрс хуулагдах ба шимтхөрсний овоолгыг стандартын дагуу тусад нь үүсгэж хадгалаагүй нөхцөлд хөрсний чанар алдагдаж болзошгүй	<ul style="list-style-type: none"> - Бохир хөрсийг хусаж зайлуулах, талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ хийх ажилд өртөж эвдэрсэн талбайн 50 %-д буюу 0.08 га талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн сэргээлт, тохижилтын ажлууд хийх - Газар шорооны ажлын үед бохирдсон хөрс ба шимт хөрсний овоолгуудыг тусад нь үүсгэж стандартын дагуу хадгалах ба барилгын ажил дуусах үед нөхөн сэргээлтэд ашиглах 	<ul style="list-style-type: none"> - Төслийн газар шорооны ажлын дараа ухсан нүхээ буцаан шороогоор дүүргэлт хийж, хөрсөө нягтаршуулан техникийн нөхөн сэргээлт хийсэн. - Газар шорооны үед гарсан хөрсний овоолгуудыг стандартын дагуу хадгалж барилгын ажлын дараа нөхөн сэргээлтэд ашигласан. 	Үйл ажиллагааны зардал	
18	Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн бохирдол үүсгэж болзошгүй.	<ul style="list-style-type: none"> - Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх - Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх - Бетон зуурмаг тээвэрлэх, буулгах, хучилт хийх ажлуудыг нарийн чанд горимын дагуу 	<ul style="list-style-type: none"> - Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийлгэсэн. Гэмтэл саатал гарсан тээврийн хэрэгсэл бүртгэгдээгүй. 	Барилгын ажлын төсөвт багтсан	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
		тогтоосон талбайн хүрээнд гүйцэтгэж, хөрсөнд асгаралт үүсгэхээс сэргийлэх			
19	Хог хаягдал, кемпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдол зэргээс үүдэлтэй хөрсний бохирдол үүсэж болзошгүй.	<ul style="list-style-type: none"> - Барилгын ба ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх - Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох - Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх - Барилгын түр кемпийн ариун цэврийн байгууламжийн нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх 	<ul style="list-style-type: none"> - Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгах зориулалттай хогийн сав байршуулсан (Зураг-3) - Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглож, ажилчдад талбайн инженер анхааруулж ажилласан. - Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байсан. - Ариун цэврийн байгууламжид ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн (Зураг-4). 	Үйл ажиллагааны зардал	
Нийт					
6. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ					
20	Хүний замбараагүй үйл ажиллагааны улмаас Сэлбэ голын сав газрын ургамлан нөмрөг талхлагдан бохирдож болзошгүй	<ul style="list-style-type: none"> - Сэлбэ голын орчимд усны хамгаалалтын бүс тогтоож, хамгаалалтын бүсэд машин тэрэг угаах, түлш цэнэглэх, хог хаях болон аливаа барилгын үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглох 	<ul style="list-style-type: none"> - Сэлбэ голын орчимд усны хамгаалалтын бүс тогтоож, хамгаалалтын бүсэд машин тэрэг угаах, түлш цэнэглэх, хог хаях болон аливаа барилгын үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглож нийт ажилчдад талбайн инженер анхааруулан ажиллаж байсан. 	-	
Нийт					
7. НИЙГЭМ, ОЛОН НИЙТЭД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ					
21	Бохир хөрсийг хусаж зайлуулах, талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ хийх ажлуудаас тоосжилт үүсэж явган болон машинтай зорчигчийн үзэгдэх орчныг хязгаарлах	<ul style="list-style-type: none"> - Газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд 1 м² талбайд 2-4 л нормын дагуу тогтмол усалгааг хийх - Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс газар шорооны ажлыг түр зогсоох - Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх 	<ul style="list-style-type: none"> - Төслийн газар шорооны ажил явагдаж буй үед хуурайшилттай өдрүүд тохиогоогүй. - Газар шорооны ажлын үед орчныг тоос тоосонцрын бохирдол багатай байх арга хэмжээ авч ажилласан. 	Агаарын чанарын хэсэгт төлөвлөсөн төсвийн дагуу	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
22	Барилгын материал тээвэрлэх, газар шорооны ажлуудаас дуу чимээ үүсэж ойр орчмын оршин суугчдын тав тухыг алдагдуулах	<ul style="list-style-type: none"> - Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх - Шаардлагатай тохиолдолд дуу чимээ тусгаарлах зөөврийн хана ашиглах - Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх 	<ul style="list-style-type: none"> - Төсөлд ашиглаж буй тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулан тэнцсэн гэсэн бичгийг тус бүр авсан. - Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэж байсан. 	Барилгын ажлын төсөвт тусгасан	ОХШХ-т тусгасан
23	Үерээс хамгаалах сувагт тохижилтын ажил хийгдэх үед орц гарц, зорчих зам түр хугацаанд хаагдаж боогдох	<ul style="list-style-type: none"> - Тохижилтын ажлын улмаас тухайн замыг түр хаасан талаар болон тээврийн хэрэгсэл ба явган зорчигчийн зорчих хөдөлгөөнд зориулан тогтоож өгсөн түр маршрутыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулах - Барилгын ажил явагдаж буй цэгүүдийн ойр орчимд явган хүн ба тээврийн хэрэгсэл чөлөөтэй зорчих зам, орц гарцыг бий болгож өгөх - Барилгын материал хураах, хөрсний овоолго үүсгэх цэгийг сонгохдоо оршин суугчдын хөдөлгөөнд саад учруулах буюу орц гарцыг хаахгүй байхаар төлөвлөх 	<ul style="list-style-type: none"> - Газар шорооны ажлын үед орц гарцыг хаасан тохиолдолд бусад зам маршрутыг харуулсан тэмдэг тэмдэглэгээ, мэдээллийн самбарыг хангалттай байршуулсан. 	Үйл ажиллагааны зардал	
24	Тохижилтын ажлын үед үерээс хамгаалах сувагт хүн унаж гэмтэх буюу халтирч унах эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Үерээс хамгаалах сувгийг гаталдаг явган хүний гүүр буюу гол жимийг хороо, хэсгийн ахлагч нарын тусламжтайгаар тогтоож, тэдгээрийг тохижилтын ажлын улмаас түр хаах тохиолдолд явган зорчигчид зориулсан түр гарц буюу жимийг тогтоож өгч, тухайн хэсэгт мэдээллийн самбар байрлуулна - Явган зорчигчид зориулсан түр гарц буюу жим нь 20 хэмээс илүүгүй налуутай, 2-3 хүн хангалттай зөрөхүйц өргөн, хур бороотой үед шавар шавхай, халтиргаа гулгаа үүсэхээргүй, хүүхэд, ахмад настнууд саадгүй зорчиж 	<ul style="list-style-type: none"> - Үерээс хамгаалах сувгийг гаталдаг явган хүний гүүр буюу гол жимүүд дээр мэдээллийн самбар тэмдэг байршуулсан. - Явган зорчигчид зориулан үерээс хамгаалах сувгийг гатлах түр гарц буюу жимийг үүсгэхдээ стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. 	Үйл ажиллагааны зардал	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
		чадахуйц, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх шаардлагатай - Явган зорчигчид зориулан үерээс хамгаалах сувгийг гатлах түр гарц буюу жимийг үүсгэж өгөхдөө хоёр талын далангаас өгсөж уруудах цементэн шат хийж өгсөн байх шаардлагатай			
25	Зүсэх, бутлах, гагнах ажлуудын үед хэлтэрхий буюу гагнуурын оч үсэрч явган зорчигчийг гэмтээж болзошгүй	- Зүсэх, гагнах ажлууд хийгдэх цэгүүдийг тойруулж хамгаалалтын хашлага татах, анхааруулах тэмдэг байршуулах	- Зүсэх, гагнах ажлууд хийгдэх цэгүүдийг тойруулж хамгаалалтын хашлага татах, анхааруулах тэмдэг байршуулж ажилласан.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	
26	Цемент, элс зэрэг нунтаг материал агаарт дэгдэж үзэгдэх орчныг хязгаарлаж болзошгүй	- Цемент, элс зэрэг нунтаг материалыг битүү орчинд буюу тусгайлсан саванд хадгалах	- Барилгын ажлын үед цемент, элс нунтаг материалыг зориулалтын саванд хадгалж байсан.	Үйл ажиллагааны зардал	
27	Барилгын материал тээвэрлэх үед зам тээврийн осол аваар гарах буюу ус зөөж буй хүүхдүүд, явган зорчигчдын аюулгүй байдал эрсдэл учруулж болзошгүй	- Хүнд даацын машины жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын давтан сургалтад хамруулах, гэр хорооллын суурьшлын бүс дунд үүсэж болзошгүй эрсдэл, осол аваарын талаар тайлбарлан таниулах - Гэр хороолол дунд тээврийн машины хурдыг хязгаарлах дүрэм мөрдүүлэх - Тээврийн жолооч нарт худаг, хүүхдийн сургууль, цэцэрлэг, явган хүний гарц, уулзвар зэрэг осол аваар гарах эрсдэл бүхий цэгүүд дээр 5 секунд зогсоод хөдлөх дүрэм мөрдүүлэх	- Машины жолооч, ажилчдыг ажлын талбайд гарахаас өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж байсан.	Үйл ажиллагааны зардал	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
28	Барилгын материал, хаягдал шороон материал тээвэрлэх тээврийн хэрэгслийн байнгын хөдөлгөөний улмаас 7 буудал, хойд зуслан чиглэлийн замын ачаалал нэмэгдэх	<ul style="list-style-type: none"> - Бохир хөрсийг хусаж зайлуулах, талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ хийх зэрэг хаягдал шороон материал их хэмжээгээр үүсгэдэг газар шорооны ажлуудыг зуслангийн оргил ачааллын улирал (6-8-р сар) эхлэхээс өмнө (4-5-р сард) буюу дараа нь (9-10-р сард) гүйцэтгэх ажлын хуваарь, төлөвлөгөө гаргах - Барилгын материал, хаягдал шороон материал тээвэрлэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг замын хөдөлгөөний оргил ачааллын цаг болох өглөө 07:00-10:00 цаг болон орой 17:00-20:00 цагуудаас зөрүүлсэн цагийн хуваарь гаргах 	<ul style="list-style-type: none"> - Төслийн ажил 5 сараас бэлтгэл хийгдэж 6-р сард эхэлсэн бөгөөд одоогоор ажлын гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна. Төслийн үйл ажиллагааны үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг авто замын хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар зохицуулж ажилласан. 	Ажлын төсөвт багтсан	
29	Тохижилтын ажил явагдаж буй цэгт явган зорчигч гэмтэж осолдох	<ul style="list-style-type: none"> - Газар шорооны болон бусад төрлийн тохижилтын ажил явагдаж буй цэгүүдийг хамгаалалтын торон хашлагаар хашиж хүрээлэх, анхааруулах тэмдэг байрлуулах 	<ul style="list-style-type: none"> - Газар шорооны болон бусад төрлийн тохижилтын ажил явагдаж буй цэгүүдийг хамгаалалтын торон хашлагаар хашиж хүрээлэх, анхааруулах тэмдэг байрлуулж ажилласан. 	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	
30	Кемпийн орчинд хог хаягдал, бохир усыг замбараагүй зайлуулснаас үүдэн орчны бохирдол, үнэр танар үүсгэх	<ul style="list-style-type: none"> - Барилгын түр кемп бүрт дараах эрүүл ахуйн үндсэн шаардлагууд тавигдана. Үүнд: 1. Хатуу хог хаягдлын менежмент. Хатуу хог хаягдлыг түр хадгалах зориулалтын цэг бий болгож, хашлага хамгаалалт хийж, тэмдэг тэмдэглэгээ байршуулах, СБД-ийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлыг 7 хоногт 2 удаа ачуулж байх 2. Шингэн хог хаягдлын менежмент. Кемпээс гарах бохир усыг битүү саванд түр хадгалж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх 3. Ажилчдын ариун цэврийн байгууламж. Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байх, ариун цэврийн байгууламжийн нүхэнд био-бэлдмэл ашиглаж халдваргүйжүүлэлт хийх, ойр орчмыг нь хлораминт шингэнээр тогтмол ариутгаж цэвэрлэх 	<ul style="list-style-type: none"> - Төслийн үйл ажиллагаанаас барилгын болон ахуйн хог хаягдлыг тухай бүр ангилсан хогийн саванд цуглуулан Цагаан давааны хогийн цэгт кг-р тооцон тушаадаг. - Ажилчдын түр оффисыг түрээсийн хашаа байшин түрээсэлж байсан. Түр оффисын ариун цэврийн байгууламжийг тухай бүр ариутгаж, халдваргүйжүүлэлт хийсэн. 	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
31	Кемпийн орчинд сахилга бат, хэв журмын зөрчил гаргаж оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	<ul style="list-style-type: none"> - Барилгын ажилчдыг БОМТ, эрүүл ахуйн сургалтад хамруулж, зөрчлийн хуулийн холбогдох заалтуудыг сурталчлан таниулсан байх - Кемпийн орчинд мөрдөх дотоод журамд сахилга батын асуудлыг нарийвчлан тусгаж өгөх ба үүнд согтууруулах ундаа хэрэглэх, ойр орчмын оршин суугчидтай асуудал зөрчил үүсгэх зэргийг хатуу хориглох 	<ul style="list-style-type: none"> - Ажилчдад байгууллагын дотоод дүрэм журмыг таниулах, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтыг тогтмол зохион байгуулдаг. 	Үйл ажиллагааны зардал	
32	Тохижилтын ажилд ашиглагдах хүнд даацын машин механизмууд осол аваар гаргаж болзошгүй	<ul style="list-style-type: none"> - Бетон зуурмаг тээвэрлэгч, дэвсэгч зэрэг том оврын машин тэрэгний ажлын үед хяналтын дохиурчныг зайлшгүй ажиллуулах шаардлагатай ба том оврын машин тэрэг ухрах, эргэх маневруудыг зөвхөн хяналтын дохиурчны дохиогоор хийж гүйцэтгэх 	<ul style="list-style-type: none"> - Төслийн хугацаанд барилгын ажилд ашиглах том техникийн ажлын үед хяналтын дохиурчныг ажиллуулж аюулгүй байдлын хангаж ажиллаж байсан. 	Үйл ажиллагааны зардал	
		Барилгын түр кэмпэд ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	Төслийн талбайд түр хаягдлын цэг байгуулсан ба үйл ажиллагаанаас үүдэлтэй ахуйн болон барилгын хог хаягдлыг нэг цэгт цуглуулан тухай бүрт нь ачуулж хаядаг.	
		ЧД-ийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлыг хог хаягдлын нэгдсэн цэгт тээвэрлэн хүргэх ажлыг гүйцэтгүүлэх		
		Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох		
		Барилгын ажил явагдаж буй газруудад зориулалтын хогийн сав байрлуулах		
		Барилгын түр кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх		Бохир ус, шингэн хог хаягдлыг кемпийн нойлд тухай бүрт нь асгаж зайлуулсан.
		Барилгын түр кэмпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх биобэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх		Барилгын түр кэмпийн бие засах газарт ариутгал халдваргүйжүүлэлт тогтмол хийсэн. /зураг 10-т үзүүлэв/
		Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих		Хяналт тавин ажилласан.

	<p>Барилгын хог хаягдлын менежмент</p>	<p>1. Барилгын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах хэрэгцээ, төрлөөр нь ангилан ялгана. 2. Барилгын ажил дуусах үед үүссэн хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, талбайг чөлөөлнө. 3. Барилгаас үүссэн дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг зайлуулах зөвшөөрлийг ЧД-ийн Засаг даргаас авч, хог хаягдлын төвлөрсөн цэгт тээвэрлэн зайлуулна. 4. Барилгын хог хаягдал тээвэрлэх ажлыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хийж гүйцэтгүүлнэ. 5. Барилгын хог хаягдал тээвэрлэх машиныг нийслэлийн нэгдсэн GPS-ийн хяналтын системд бүртгүүлсэн байх 6. Хог хаягдлыг зориулалтын цэгээс бусад газар хаяхгүй байх 7. Барилгын хог хаягдал тээвэрлэх тэвштэй буюу өөрөө буулгагч тээврийн хэрэгсэл нь хог хаягдлыг гээгдэхээс хамгаалах зориулалтыг хэрэгсэлтэй, өндөрлөгөө, хашлага, бүтээлэгтэй байх</p>	<p>Хог хаягдал хадгалах хашаа бүхий цэгийг сар тутам ариутгал, цэвэрлэгээ хийдэг. Газар шорооны ажлын үед үүссэн хаягдлуудыг тээвэрлэн, зайлуулдаг. Барилга угсралтын ажлын дараа талбай дээр үлдсэн үлдэгдэл материал, хог хаягдал, бохирдсон хөрс зэргийг холбогдох журмын дагуу хаяж зайлуулсан. /зураг 10-т үзүүлэв/ Төслийн үйл ажиллагаанаас гарсан ахуйн болон барилгын хог хаягдлыг цаг тухай бүрт нь хаяж зайлуулсан.</p>
	<p>Хаягдал шороон материалын менежмент</p>	<p>1. Газар шорооны ажлаас үүсэх хаягдал шороон материалыг Цагаандавааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг ЧД-ийн захиргаанаас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө. 2. Хаягдал шороон материалыг их хэмжээгээр хуримтлуулалгүйгээр тухай бүрт зайлуулж байх 3. Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын ялгарал, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана.</p>	<p>Барилгын ажлын үед үүссэн хог хаягдлыг Цагаандавааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулсан. Үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг түр хугацаанд бөөгнөрүүлж битүүмжлэн хог хаягдлын нэгдсэн цэгт тухай бүрт нь ачуулан хаясан. Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын ялгарал, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг ТУН-д тайлагнан ажилласан.</p>

Зураг 6-1. Ажилчидын кемпийн зохион байгуулалт, хог хаягдлын цэг байршуулсан байдал.



Ажилчидын түр кемп



Хог хаягдлын цэг



Ажилчидын 00



Тос масло солих талбай

6.1.2 DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц

Хүснэгт 6-1. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлын ангилал	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн өртөг, ₮	Нийт зардал, ₮	
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллага нь Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж ТУН-ээр хянуулж, хэрэгжүүлж ажиллана Сүхбаатар дүүргийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж ажиллах	- Төслийн үйл ажиллагаанаас гарах техникийн болон ахуйн хог хаягдлыг ангилан ялгах хогийн саванд цуглуулан Цагаан давааны хогийн цэгт кг-р тооцоон тушаадаг. - Барилгын түр кемпээс гарч байгаа ахуйн хог хаягдлыг тогтсон нэг цэгт цуглуулж, хогийн цэгийн хашлага хамгаалалтаар хааж байсан.	Үйл ажиллагааны зардлаар		
	Барилгын түр кемпэд ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	- СБД-ийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлын нэгдсэн цэгт тээвэрлэн хүргэх ажлыг гүйцэтгүүлэх	- СБД-ийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж хог хаягдлыг нэгдсэн нэг цэгт хаяж зайлуулж байсан.	Үйл ажиллагааны зардлаар	Гэрээний үнийн дүнгээр
	Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох	- Төслийн хугацаанд гарах хог хаягдлыг ил задгай хаяж, зөвшөөрөлгүй газарт хураахыг хатуу хориглож, тогтсон нэг цэгт хаяхыг анхааруулж ажиллаж байсан.	- Төслийн хугацаанд гарах хог хаягдлыг ил задгай хаяж, зөвшөөрөлгүй газарт хураахыг хатуу хориглож, тогтсон нэг цэгт хаяхыг анхааруулж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардлаар	
	Барилгын ажил явагдаж буй газруудад зориулалтын хогийн сав байрлуулах	- Барилгын ажлын явагдаж буй талбай бүрд зориулалтын ангилан ялгах хогийн сав байршуулж ажиллаж байсан.	- Барилгын ажлын явагдаж буй талбай бүрд зориулалтын ангилан ялгах хогийн сав байршуулж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардлаар	
	Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх	- Төслийн хугацаанд түр кемпээс үүссэн шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулаад нэгдсэн нэг цэгт хаяж зайлуулж байсан.	- Төслийн хугацаанд түр кемпээс үүссэн шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулаад нэгдсэн нэг цэгт хаяж зайлуулж байсан.	Үйл ажиллагааны зардлаар	
	Барилгын түр кемпийн ариун цэврийн байгууламжийн нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био- бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминд цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх	- Төслийн хугацаанд ариун цэврийн байгууламжийг бохирдлоос сэргийлж тогтмол хугацаан био бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминаар тогтмол ариутгаж байсан.	- Төслийн хугацаанд ариун цэврийн байгууламжийг бохирдлоос сэргийлж тогтмол хугацаан био бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминаар тогтмол ариутгаж байсан.	Үйл ажиллагааны зардлаар	
	Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих	- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хогийн цэгт тогтмол үзлэг хийж хяналт тавьж ажиллаж байсан.	- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хогийн цэгт тогтмол үзлэг хийж хяналт тавьж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардлаар	

7 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

7.1.1 DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.

БОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ энд заагдсан бохирдуулах эх үүсвэрүүдийг хянах Монгол Улсын хууль тогтоомж, стандартчилагдсан арга зүйн хязгааруудыг баримтлах шаардлагатай ба дээрх эрх зүйн актууд, стандартууд шинэчлэгдвэл түүний шинэчилсэн хувилбарыг мөрдөж ажиллах ёстой. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорх асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Төслийн хүрээнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, батлагдсан арга зүйг баримтлан стандартчилагдсан багаж, хэрэгслээр дээж, шинжилгээ хийх болон өгөгдлийг боловсруулах ажлыг төслийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд удирдан явуулж хяналт шинжилгээний хөтөлбөрийг тусгай эрхтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж дүгнэлт гаргууллаа. 2023 оны орчны хяналт шинжилгээний ажлын төлөвлөгөөг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 7-1 Байгаль орчны хяналт, шинжилгээний төлөвлөгөө

Гэрээний дугаар, төслийн нэр	Хяналтын үзүүлэлт	Байршил	Хугацаа, давтамж	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага
Бизнес инкубатор, сургалтын төв байгуулах барилга угсралтын ажил	Агаарын чанарын мониторинг SO ₂ , NO ₂ , TSP PM10, дуу чимээ	Барилгын ажлын талбайд	Барилгын ажлын явцад, жилд 1 удаа	Төслийн гүйцэтгэгч “Янчен Шингуо Констракшн Инженеринг” ХХК
	Хөрсний чанар: хөрсний хими физик шинж чанар, хөрсний бохирдол	Барилгын ажлын талбайд	Барилгын ажлын явцад, жилд 2 удаа	
	Усны чанар: Усны хими, бохирдлын шинжилгээ	Унд ахуйд хэрэглэж буй усны эх үүсвэр	Барилгын ажлын явцад, жилд 2 удаа	
	Эрүүл ахуйн хяналт шинжилгээ: Хог хаягдлын цэг, ажилчдын 00, амрах байр, ажлын орчин нөхцөлд хяналт хийх	Ажилчдын түр кэмп, барилгын ажлын талбай, хог хаягдлын цэг	Барилгын ажлын явцад, жилд 2 удаа	
	БОМТ-ийн хэрэгжилтэд хяналт тавих	Барилгын ажлын талбайд	Сард 4 удаа	

Тус төслийн хувьд Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөрийг 2023 онд бүрэн биелүүлж ажилласан. Хөрс, ус, агаарын чанарын шинжилгээг итгэмжлэгдсэн лаборатори мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, үр дүнг дараах хүснэгтүүдэд үзүүлэв.

Хүснэгт 7-2. Агаарын чанарын хяналт, шинжилгээний үр дүн

Гэрээний дугаар, төслийн нэр	Хяналтын үзүүлэлт	Биелэлт
Бизнес инкубатор, сургалтын төв байгуулах барилга угсралтын ажил	Агаарын чанарын мониторинг SO ₂ , NO ₂ , PM 2.5, PM10, дуу шуугиан	Агаарын чанарын хэмжилтийг SO ₂ , NO ₂ , PM 2.5, PM10, дуу шуугиан гэсэн 5 үзүүлэлтээр Dust Trak багажаар 2023 оны 5-р сард хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн дүнгээр бүх үзүүлэлтүүд зөвшөөрөгдөх хэмжээнд байсан. Дуу чимээний түвшинг зөөврийн ENVIRONMENT METER 4IN буюу 4 үзүүлэлтийг /агаарын харьцангуй чийг, температур, дуу чимээ/ хэмжих зориулалттай багжаар хэмжилт хийсэн. /Хавсралт 5-т үзүүлэв/



Зураг 11. Агаарын чанарын хяналтын дээжлэлт

Хүснэгт 3. Агаарын чанарын шинжилгээний дүн

№	Цэгийн дугаар	Сорьц авсан өдөр	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ ДБА
1	Кемд орчимд	2023.05.15	0.019	0.023	0.029	44
2	УСДДТ 1-р барилга зам дагуу	2023.05.15	0.021	0.025	0.107	60
Агаарын чанарын стандарт MNS4585:2016			0.450	0.200	0.500	60


Хэмжилтийн үр дүнгээс харахад Агаарын чанарын стандарт MNS4585:2016-ын хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Хүснэгт 7-3 . Хөрсний чанарын хяналт, шинжилгээний үр дүн

Гэрээний дугаар, төслийн нэр	Хяналтын үзүүлэлт	Биелэлт
Бизнес инкубатор, сургалтын төв байгуулах барилга угсралтын ажил	Хөрсний төлөв, ерөнхий хими физик шинж чанар, элэгдэл эвдрэлийн нөхцөл, хөрсний хүнд метал болон эрүүл ахуй	Хөрсний дээжлэлтийг хийхдээ төслийн талбайд нөхөн сэргээлт хийгдсэн цэгээс 2023 оны 5 болон 9-р сард авч, шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээр хөрсний үржил шимийн агууламж багаас дунд зэрэг, сул шүлтлэг орчинтой, үржил шимийн агууламж багаас дунд зэрэг, хөнгөн шавранцар механик

Гэрээний дугаар, төслийн нэр	Хяналтын үзүүлэлт	Биелэлт
		бүрэлдхүүнтэй. Хөрсний эрүүл ахуйн буюу нянгийн бохирдол авто зам шугам сүлжээ тавигдаж буй талбайд илрээгүй харин кемпийн 00-оос /E.coli/ буюу гэдэсний савханцар үүсгэгч бактери бага зэрэг илэрсэн. Хүнд металын бохирдол нь MNS 5850:2019 стандартын хүлцэх агууламжаас даваагүй байна. Хөрсний шинжилгээний дүнг тайланд хавсаргав. /Хавсралт 5-т үзүүлэв/

Зураг 7-1 Хөрсний чанарын хяналтын, дээжлэлт



Хүснэгт 7-4 Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Дээжний нэр	Гүн см	pH	Давс, %	ЦДЧ	CO ₂ , %	Ялзмаг %	Шингээгдсэн сууриуд, мг-экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/ 100 гр	
								Ca+Mg	Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
2023.05.15												
1	Дээж-1	0-30	8.14	0.08	0.159	0.00	5.71	28.6	27.0	1.6	3.3	78
2	Дээж-2	0-30	8.45	0.15	0.301	0.33	3.90	19.2	16.0	3.2	3.7	37
2023.09.20												
1	Дээж-1	0-30	7.98	0.067	0.162	0.00	5.62	29.0	25.0	4.0	2.9	78
2	Дээж-2	0-30	8.12	0.131	0.297	0.32	3.51	22.0	16.0	6.0	3.2	58

Хүснэгт 7-5. Хөрсний механик бүрэлдэхүүний шинжилгээний дүн

№	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
			1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
2023.05.15									
1	Дээж-1	0-30	18.7	16.9	35.5	8.4	10.6	9.9	28.9
2	Дээж-2	0-30	27.2	32.4	16.5	8.4	7.7	7.8	23.9
2023.09.20									
1	Дээж-1	0-30	20.0	19.6	31.6	9.2	9.5	10.1	28.8
2	Дээж-2	0-30	24.9	34.0	18.3	7.8	8.1	6.9	22.8

Шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсний урвалын орчин 7.98-8.45 буюу сул шүлтлэг орчинтой, үржил шимийн үзүүлэлт болох ялзмагийн агууламж 3.51-5.71% багаас дунд зэрэг, шингээгдсэн сууриудын нийлбэр 19.2-29.0 мг-экв/100 гр бага зэрэг, шим тэжээлийн элементүүдийн хангамж дунд зэрэг байна. Хөрсний механик бүрэлдэхүүн хөнгөн шавранцар байна.

Хүснэгт 7-6 Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

№	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
			Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
2023.05.15								
1	Дээж-1	0-30	32.8	-	30.1	29.0	42.8	28.4
2	Дээж-2	0-30	10.0	-	20.9	20.2	78.9	21.4
2023.09.20								
1	Дээж-1	0-30	29.4	-	25.3	28.1	39.8	24.9
2	Дээж-2	0-30	16.8	-	22.4	21.9	62.4	18.7
Шавранцар хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ			100.0	1.5	70.0	80.0	150.0	100.0
Элсэнцэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ			60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт			/MNS 5850:2019/					

Хүснэгт 7-7. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн

Дээжний нэр	Нянгийн тоо	Гэдэсний савханцарын титр (E.coli)		Анаэробын титр (CL.perfringens)	
	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
2023.05.15					
Дээж-1	1.3*10 ⁵	0.1	Бага зэрэг бохирдолтой	0.1<	Цэвэр
Дээж-2	1.0*10 ⁴	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр
2023.09.20					
Дээж-1	2.0*10 ⁴	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр

1-р дээжийг авто зам шугам сүлжээ дэд бүтцийн ажлын кемп дэхь 00-ын хажуугаас авсан /E.coli/ буюу гэдэсний савханцар үүсгэгч бактериар бага зэрэг бохирдсон гэж гарсан байна. Харин 9-р сард тус цэгээс авсан шинжилгээгээр гэдэсний савханцар үүсгэгч бактерийн бохирдолгүй гарсан байна. Ажлын явцад хог хаягдлын цэг болон 00 орчимд ариутгал цэвэрлээгээг хийсэнтэй холбоотой юм. Мөн дээрх шинжилгээний үр дүнгээс харахад төслийн авто зам шугам сүлжээ тавигдаж буй талбайд хөрс хүнд металлын болон нянгийн бохирдолгүй байна. Шинжилгээний хариу хавсаргав.

Хүснэгт 7-8. Усны чанарын хяналт, шинжилгээний үр дүн

Гэрээний төслийн нэр	дугаар,	Хяналтын үзүүлэлт	Биелэлт
Бизнес сургалтын байгуулах угсралтын ажил	инкубатор, төв барилга	Усны физик химийн шинж чанар, хими бактериологийн шинжилгээ,	Ажилчдын унд ахуйн усыг ойролцоох гүний худгийн уснаас дээжлэлт хийж, шинжлүүлсэн. Усны шинжилгээний дүнгээр ажилчдын хэрэглэж буй ундны ус нь МУ-ын Ундны усны стандартад нийцсэн байв. Усны чанарын шинжилгээний дүнг тайланд хавсаргав.

Зураг 13. Усны чанарын хяналтын, дээжлэлт



Усны ерөнхий химийн шинжилгээг 2023.05 сард болон 09 саруудад төслийн талбай дахь унд ахуйн уснаас авч “НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК-ний итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнгээс үзвэл химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, 1-р төрлийн нэн цэнгэг буюу ялимгүй эрдэсжилттэй маш зөөлөн ус байна. Шинжилгээний хариу хавсаргав. /Хавсралт 5-т үзүүлэв. /

Хүснэгт 7-9. Усны хүнд металлын шинжилгээний дүн

№	Лаб дугаар	Дээжний нэр	Агууламж мг/л					
			Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/
1	2023.05.12	Дээж-1	0.000	<0.01	0.00	0.004	0.00	0.00
2	2023.09.20	Дээж-2	0.000	<0.01	0.00	0.004	0.00	0.00
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ / MNS 4943:2015/			0.2	0.03	0.1	3.0	0.3	1.0

Хүснэгт 7-10. Усны шинжилгээний эрүүл ахуйн шинжилгээний дүн

Лабораторийн дугаар	Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлтийн нэр хэмжих нэгж	Шаардлага	Шинжилгээний хариу
Дээж-1	MNS ISO 6222:1998	ББЕТ	1мл-т 100-аас ихгүй	1.0*10 ¹
	MNS ISO 9308-1:1998	Гэдэсний бүлгийн нян	100 мл-т илрэхгүй	илрээгүй
	MNS ISO 19250:2017	Salmonella spp	25 мл-т илрэхгүй	илрээгүй
Дээж-2	MNS ISO 6222:1998	ББЕТ	1мл-т 100-аас ихгүй	1.0*10 ¹

Лабораторийн дугаар	Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлтийн нэр хэмжих нэгж	Шаардлага	Шинжилгээний хариу
	MNS ISO 9308-1:1998	Гэдэсний бүлгийн нян	100 мл-т илрэхгүй	илрээгүй
	MNS ISO 19250:2017	Salmonella spp	25 мл-т илрэхгүй	илрээгүй

Шинжилгээний үр дүнгээс харахад унд ахуйн усны эрүүл ахуй болон хүнд металлын бохирдолгүй байгаа нь харагдаж байна. Шинжилгээний хариу хавсаргав

7.1.2 DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц

Хүснэгт 7-11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэг байршил	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
Хөрсөн бүрхэвч					
1	- Хөрсний агрохимийн үзүүлэлт, хүнд металлын зарим элементүүд (Pb, Zn, Cd, Cr, Ni, Co)-ийг тодорхойлох,	- Төслийн талбайд 2 цэгт	Хөрсний агрохими, хүнд металл, хөрсний эрүүл ахуйн дээжийг 200-300 гр хэмжээтэй авч “Инженер геодези” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав).	25,000.0	106,000.0
Агаарын чанар					
2	Агаарын чанар, физик бохирдлыг тодорхойлох зорилгоор NO ₂ , SO ₂ болон нийт тоос, дуу чимээ зэрэг үзүүлэлтийг тодорхойлох	- Төслийн талбайд 2 цэгт	Агаарын чанарын дээжийг 2 цэг тус бүрээс сорьц авч Цаг уур орчны шинжилгээний газар Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав).	36,000.0 /томилолт 72,000.0/	108,000.0
Усны чанар					
3	Усны чанарын үндсэн үзүүлэлт	- Унд, ахуйн хэрэглээний уснаас-1 цэг	Унд, ахуйн хэрэглээний уснаас нэг усны сорьц авч “Инженер геодези” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав).	45,000.0	45,000.0
Нийт дүн					274,100.0



Зураг 7-2. Хөрсний дээж авч буй фото зураг




Зураг 7-3. Агаарын сорьц авч фото зураг

8 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

УБХХОДХ 2-р үе шатанд хэрэгжиж буй “Дамбадаржаа дэд төв барих” төслийн БОМТ 2023 тайлангийн “Удирдлага зохион байгуулалтын менежмент”-ийг доор авч үзэв.			
<p>Баянхошуу нийгмийн барилга байгууламж барих төслийн барилгын ажлын явцад:</p> <ol style="list-style-type: none"> 1. ТУА –ийн байгаль орчин, нийгмийн мэргэжилтэн нь байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, нийгмийн асуудлыг бүхэлд нь хариуцдаг ба дэд төслүүдийн гүйцэтгэгч, БО, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөх байгууллагууд, тэдгээрийн хүмүүстэй харилцах ажлыг хариуцаж, ТУА зохицуулагч, төрийн захиргааны байгууллага, АХБ-ны хүмүүст ажлын явц, үр дүнг танилцуулж, хүргэх, батлуулах ажлыг хариуцдаг. 2. Гэрээт гүйцэтгэгч байгууллагуудын байгаль орчны мэргэжилтнүүд нь БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих, сургалт зохион байгуулах, талбайн мониторингийн ажлыг хийж гүйцэтгэх, ажлын үр дүнг ТУА-д тайлагнах зэрэг чиг үүрэгтэй ажиллана. 3. Байгаль орчны хөндлөнгийн хяналтын байгууллага талбайд ажиллах, ТУА-д зөвлөгөө өгөх, туслах ажлыг гүйцэтгэнэ. 4. УБХХОДХ хэрэгжүүлэгч нь барилгын гүйцэтгэгч нараас БОМТ биелэлтийн тайланг тухайн оны 09 дүгээр сарын 25-ний дотор хүлээн авна. 			
Албан тушаал	ТУА-ийн Байгаль орчны мэргэжилтэн	Хаяг	Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн байр
Нэр	З.Мөнх-Оргил	Утас	976 (70003099)
Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ			
<p>Байгаль орчныг хамгаалах, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн дагуу төсөл хэрэгжүүлэгч нь төслийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг төрийн захиргааны байгууллагаар хийлгэж, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг тусгай зөшөөрөл бүхий байгууллагаар хийлгэж ажиллана Дамбадаржаа дэд төв барих төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, 2020 он, Эс И Си ХХК</p>			
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлт:			
<p>БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ “3.3.Төсөл хэрэгжүүлэгчээс тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймаг, НБОГ түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулж, ажилуулан дүгнэлтийг 12 дугаар сарын 1-ний дотор гаргуулах ба уг ажлын хэсэгт аймаг нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орно” гэж заасан.</p> <ul style="list-style-type: none"> – УБХХОДХ хэрэгжүүлэгч нь барилгын гүйцэтгэгч нараас БОМТ биелэлтийг тухайн оны 10 дугаар сарын 1-ний дотор хүлээн авна. – УБХХОДХ хэрэгжүүлэгч бүх гүйцэтгэгчийн БОМТ биелэлтийн тайланг “НБОГ”-т жил бүр 11 дүгээр сард хүргүүлж, биелэлтийг дүгнүүлж ажиллана. – УБХХОДХ хэрэгжүүлэгч нь бүх гүйцэтгэгчийн дараа жилийн БОМТ –ийн төлөвлөгөөг “БОАЖЯ”-д жил бүр 12 дугаар сард хүргүүлж, батлуулан, төлөвлөгөөг гүйцэтгэгч нарт танилцуулж, төлөвлөгөөний дагуу ажлын биелэлт явагдах байдалд хяналт тавьж, шаардлага ажиллана. 			

9 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 9-1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

Гүйцэтгэгч.	Төлөвлөгөө	Биелэлт
<p>DAFPE Дамбадаржаагийн үерийн сувгийн тохижилтын ажлын багц</p>	<p>Төсөл хэрэгжүүлэгч нь 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж, БОАЖЯ-аар батлуулах үүрэгтэй. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 2023 оны 11 дүгээр сарын 1 өдрийн дотор БОАЖЯ-нд хүргүүлнэ. БОАЖЯ нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авч, түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргана.</p>	<p>Төслийн танилцуулга олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг төслийн талбай хашааны үүдэнд төслийн танилцуулга болоод холбоо барих хүмүүсийн дугаарыг байршуулан ажилласан.</p> <p>Төслийн захиалагч талаас тавьсан шаардлагын дагуу батлагдсан БОМТ-ий (Захилагч талын батлуулсан) биелэлтийн тайланг 2023.0.25-ны дотор захиалагч талд хүргүүлэн ажиллав.</p> 

Гүйцэтгэгч.	Төлөвлөгөө	Биелэлт
<p>DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.</p>		 <p>Төслийн танилцуулга олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг төслийн талбай хашааны үүдэнд төслийн танилцуулга болоод холбоо барих хүмүүсийн дугаарыг байршуулан ажилласан.</p> <p>Төслийн захиалагч талаас тавьсан шаардлагын дагуу батлагдсан БОМТ-ий (Захилагч талын батлуулсан) биелэлтийн тайланг 2023.09.25-ны дотор захиалагч талд хүргүүлэн ажиллав.</p>

10 ДҮГНЭЛТ


Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 16, 17-р хороонд байрлах “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, 2-р үе шат”-ний “Дамбадаржаа дэд төв барих төсөл” төслийн DAFPE гэрээний дугаар бүхий Дамбадаржаагийн үерээс хамгаалах сувгийг тохижуулах багц болон Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн багцын 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн үр дүнд бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу боловсруулав;
- “Нью констракшн” ХХК нь дээрх төслийн DAFPE гэрээний дугаар бүхий Дамбадаржаагийн үерээс хамгаалах сувгийг тохижуулах багцын ажлыг хамтран ажиллах гэрээний дагуу хийж гүйцэтгэж байна. Тус ажлыг “Нью констракшн” ХХК нь 2023 оны 6 сарын 1-ээс эхэлсэн ба 100 хувийн гүйцэтгэлтэй ажлыг дуусгасан.
- “Янчен Шингуо Констракшн Инженеринг” ХХК дээрх төслийн DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажлын Дамба 2,5-р багц ажлын газар шорооны ажил хийгдэж дууссан байна. Үүнд шугам хоолойн суурь ухах, шугам хоолой хийх гэсэн ажлууд хийгдэж дууссан 2023 оны 5 сарын 1-ээс эхэлсэн ба 10-15 хувийн гүйцэтгэлтэй байна
- “Нью констракшн” ХХК нь 2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт **2,107,820.0** төгрөг зарцуулсан байна

11 Хавсралт материал

11.1.1 DARI-1,2 Дамба дэд төвийн авто зам, цэвэр ус дамжуулах шугам, бохир ус зайлуулах шугам сүлжээ болон холбогдох дэд бүтцийн ажил.

ХАВСРАЛТ I. АЖ АХУЙН НЭГЖИЙН ГЭРЧИЛГЭЭ




编 号 320924000201001010173

营 业 执 照

统一社会信用代码 913209246913474408


名 称	盐城兴国建设工程有限公司
类 型	有限责任公司
住 所	射阳县合德镇南苑二村27-2号(原条心村四组)
法定代表人	束长国
注册 资 本	1000万元整
成 立 日 期	2009年07月03日
营 业 期 限	2009年07月03日至*****
经 营 范 围	市政工程、园林绿化工程、城市及道路照明工程、房屋建筑工程施工；管道工程施工；地基与基础工程施工；建材、水电器材销售。（依法须经批准的项目，经相关部门批准后方可开展经营活动）



2022 4 18 2869

登记 机 关

2016 年 04 月 01 日



www. (sgs). gov. cn: 68888/ prov1nc0

企业信用信息公示系统网址: 中华人民共和国国家工商行政管理总局监制

ХАВСРАЛТ II. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ



建筑业企业资质证书
(副本)

企业名称 盐城兴国建设工程有限公司
详细地址 江苏省盐城市射阳县合德镇南苑二村27-2号
营业执照注册号 320924000086159 **法定代表人** 束长国
注册资本 1000万 **经济性质** 有限责任公司(自然人投资或控股)
证书编号 D332019114 **有效期** 2024-11-19

资质类别及等级:

可承接建筑、市政公用工程总承包和项目管理业务
机电工程施工总承包叁级
城市及道路照明工程专业承包叁级
公路工程施工、管道工程施工总承包叁级
热力电厂工程及热力管道安装、壹级
水利水电工程施工总承包贰级





发证机关:
2016 年 01 月 4 日
中华人民共和国住房和城乡建设部制



БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

/Эх хувь/

Аж ахуйн нэгжийн нэр: Янченг Шингоу Констракшн Инженеринг ХХК

Хаяг: Шө Яан гацаа, Хөдө суурин, Нан Юань Ар тосгон 27-2 тоот

Аж ахуйн нэгжийн гэрчилгээний бүртгэлийн дугаар: 320924000086159

Хуулийн этгээдийн нэр: SHU CHANGGUO

Дүрмийн сан: 10000000 юань

Аж ахуйн нэгжийн хэлбэр: ХХК /хувь хүний хөрөнгө оруулсан/

Зөвшөөрлийн дугаар: D332019114

Хүчинтэй хугацаа: 2024 оны 11-р сарын 19-ны өдөр хүртэл

Зөвшөөрлийн ангилал болон зэрэг:

Барилга байгууламж, дотоод гадна шугам сүлжээ, дулааны дэд төв, нийтийн байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэлийн 3-р зэрэг, Хот болон замын гэрэлтүүлгийн ажлын тусгай гүйцэтгэлийн 3-р зэрэг, хурдны автозамын барилга угсралт, дулааны цахилгаан станц болон шугам сүлжээ барилга угсралт, Усны барилга байгууламжийн барилга угсралт

Олгосон байгууллага: /Тамга дарагдсан/

2016 оны 01-р сарын 04-ны өдөр





ХАВСРАЛТ III. ХАБЭА-Н ДОТООД ЖУРАМ



**“ЯНЧЕН ШИНГУО КОНСТРАКШН ИНЖЕНЕРИНГ” ХХК-ИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЖУРАМ**

Дамба дэд төв

р.г. 1

	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЖУРАМ			
	Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Огноо
Баталсан:	Гүйцэтгэх захирал	BAOYIN		2023 он 08сар.....
Боловсруулсан:	ХАБЭА-н ажилтан	Д.Түвшинжаргал		2023 он 08 сар.....
Журмыг хянасан	Ерөнхий Инженер	BIE RUYUE		2023 он 08 сар.....

ТОВЬЁГ

№	АГУУЛГА	ХУУДАС
1	ЗОРИЛГО	3
2	ХАМРАХ ХҮРЭЭ	3
3	НОРМАТИВ ИШЛЭЛ	3
4	НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3-5
5	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ БОДЛОГО	5
6	ХАБЭА-Н ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ	5
7	ХАБЭА-Н ТАЛААР ИРГЭН, АЖИЛТАН БОЛОН ГЭРЭЭТ КОМПАНИ, БРИГАДУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ	5-6
8	ИРГЭН, АЖИЛТАН БОЛОН ГЭРЭЭТ КОМПАНИ, БРИГАДУУДЫН ЭРХ ҮҮРЭГ	6-7
9	ХӨДӨЛМӨРИЙН АЯТАЙ НӨХЦӨЛӨӨР ХАНГУУЛАХ АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ	7
10	ХАБЭА-Н ТУХАЙ ЗААВАРЧИЛГАА	8-9
11	ХАБЭА-Н ТУХАЙ СУРГАЛТ	9
12	ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	9-10
13	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ОСОЛД ДӨХСӨН ТОХИОЛДЛЫГ СУДЛАН БҮРТГЭХ	10
14	ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ	10-11
15	АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН ОЛГОЛТ БА АШИГЛАЛТ	11-12
16	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ БАРИМТ БИЧГИЙН ХАДГАЛАЛТ, БАРИМТЖУУЛАЛТ	12-13
17	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ	13
18	ХАБЭА-Н ТУХАЙ ЗӨРЧИЛ ГАРГАСАН АЖИЛТАНД ХАРИУЦЛАГА ТООЦОХ	13-14
19	ХАРИУЦЛАГА	14
20	ХОГ ХАЯГДАЛ	14
21	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЗАРЧИМ	14-15

pg. 2

1. ЗОРИЛГО

1.1 Энэхүү Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод журам нь “ЯНЧЕН ШИНГУО КОНСТРАКШН ИНЖЕНЕРИНГ” ХХК -н нийт ажиллагсад болон гэрээт компани, ажил гүйцэтгэх бригадуудын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх бодлого үндсэн зарчмыг тодорхойлж ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага стандартыг норм дүрмийг хангах, ажил олгогч хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ослоос урьдчилан сэргийлэх, аваар осолгүй орчин бүрдүүлж ажиллахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дотоод журам нь ажил олгогч, болон нийт ажиллагсад мөн гэрээгээр ажил гүйцэтгэж буй хуулийн этгээд, бригад, хувь хүмүүс болон дадлага хийж байгаа их, дээд сургуулийн мөн мэргэжил сургалт үйлдвэрийн төв, коллежийн суралцагч оюутан нарт хамаатай болно.
- 2.2 Нийт ажиллагсад ХАБЭА-н тухай журмын дагуу ажил үүргээ гүйцэтгэх ба хэрэгжилтэд ХАБЭА-н ажилтан, шууд удирдлага хяналт тавьж ажиллана.

3. НОРМАТИВ ИШЛЭЛ

3.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дотоод журам нь “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль”-тай мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай бусад холбогдох норм, дүрэм, журамтай нийцэж байна.

4. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1 Журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
- 4.1.1 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” гэж хөдөлмөрлөх явцад ажилтны ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг;
- 4.1.2 “Хөдөлмөрийн аюулгүй байдал” гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн төвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг;
- 4.1.3 “Хөдөлмөрийн эрүүл ахуй” гэж хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие махбод, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг;
- 4.1.4 “Хөдөлмөрийн нөхцөл” гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамарсан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг;
- 4.1.5 “Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл” гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамарсан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг;

- 4.1.6 “**Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл**” гэж хүний эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх, сэтгэхүйд өөрчлөлт оруулах, хөдөлмөрлөх чадварыг бууруулах, мэргэжлийн өвчин бий болгох уршиг бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйлийг;
- 4.1.7 “**Аюул**” гэж ажилтныг үйлдвэрлэлийн осолд хүргэж болзошгүй, эрүүл мэнд, эд хөрөнгийн болон ажлын орчны хувьд хор уршиг учруулж болзошгүй эх үүсвэр, нөхцөл байдал буюу эдгээр хүчин зүйлсийн нийлбэрийг;
- 4.1.8 “**Ажлын байр**”- иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор байх бүх байрыг;
- 4.1.9 “**Ажлын байран дахь эрсдэл**” гэж ажилтныг үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцөлийг;
- 4.1.10 “**Эрсдэлийн үнэлгээ**” гэж ажлын байран дахь эрсдэлд үнэлэлт өгөх үйл явцыг;
- 4.1.11 “**Үйлдвэрлэлийн осол**” гэж ажилтан ажил үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн хүчин зүйлийн үйлчлэлд өртөж, эрүүл мэндээр хохирох, амь насаа алдахыг;
- 4.1.12 **Үйлдвэрлэлийн осолд дөхсөн тохиолдол**” гэж ажилтан ажил үүргээ биелүүлэх явцад бага хэмжээгээр бэртэж, гэмтэж 3 хүртэл хоногийн ажлын өдрийн алдагдал гарахад хүргэсэн гэнэтийн, урьдчилсан таагүй явдал нөхцөл байдал үүссэн нь тогтоогдсон тохиолдлыг;
- 4.1.13 “**Хурц хордлого**” гэж ажилтан цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордох явдлыг;
- 4.1.14 “**Мэргэжлээс шалтгаалах өвчин**” гэж хөдөлмөрлөх явцад ажилтны бие махбодод үүссэн үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчин;
- 4.1.15 “**Ажлын тусгай хамгаалах хувцас**” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгсэл;
- 4.1.16 “**Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл**” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгсэл;
- 4.1.17 “**Хамтын хамгаалах хэрэгсэл**” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хоёр буюу түүнээс дээш тооны ажилтныг нэгэн зэрэг хамгаалах зориулалт бүхий хэрэгсэл;
- 4.1.18 “**Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал**” гэж зураг төсөл, техникийн баримт бичигт заасан нөхцөлийн дагуу тоног төхөөрөмжийг ажиллуулахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байх;
- 4.1.19 “**ХАБЭА-н хяналт**” гэж ХАБЭА-н үйл ажиллагаа, түүний үр дүн болон авч буй арга хэмжээ нь үр ашигтай, ХАБЭА-н бодлогын хэрэгжилтийг хангаж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор хийгдэх тогтмол үзлэг шалгалт;
- 4.1.20 “**Нэн түрүүнд аюулгүй байдал**” гэж ажил эхлэхээс өмнө ажлын байр, орчиндоо аюулыг илрүүлэх үзлэг хийж, илэрсэн зөрчлийг арилган, аюулгүй ажиллагаа ашиглалтын заавар, горимыг чанд мөрдөж ажиллахыг хэлнэ.
- 4.1.21 “**Техникийн осол**” гэж ноцтой аюул, эрсдэл гарсан боловч ажилтан гэмтээгүй, техник тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл, учруулсан үйлдлийг хэлнэ.
- 4.1.22 “**Ажлын байран дахь эрсдэл**” гэж ажилтныг үйлдвэрлэлийн осол хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцөлийг хэлнэ.
- 4.1.23 “**ХАБЭА-н зөрчил**” гэж хүний амь нас, эрүүл мэндэд аюул, эрсдэлтэй ажлын байр, орчин, үйлдлийг хэлнэ.

4.1.24 “Зөрчлийн хуудас” гэж ХАБЭА-н зөрчил гаргасан ажилтанд хариуцлага тооцох, баримтжуулах зорилгоор ашиглах хуудас тэмдэглэгдсэн байна.

4.1.25 “Аюулыг мэдээлэх” гэж ажилтнууд ажил эхлэхийн өмнө хяналт шалгалтыг хийснээр, аюулыг илрүүлж, “Аюулыг мэдээлэх хуудас”-ийг бөглөж / цаашид “АМХ” гэх/, салбар нэгж хэсгийн ахлах, шууд удирдлагадаа өгнө.

4.1.26 “ХАБЭА” – Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

5. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ БОДЛОГО

5.1 “ЯНЧЕН ШИНГУО КОНСТРАКШН ИНЖЕНЕРИНГ” ХХК нь нийт ажилтнуудаа компанийн хамгийн үнэ цэнэтэй баялаг гэж үзэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварыг хэвээр хадгалах, эрүүл аюулгүй орчинд хөдөлмөрлөх аюулгүй байдлыг нь хангах асуудлыг эрхэмлэж үйлдвэрлэлийн болон бусад бүхий л үйл ажиллагаанд НЭН ТҮРҮҮНД-ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН БОДЛОГЫГ гол шалгуур болгон ажиллана.

5.2 Байгууллагын нэгжийн удирдлага нь аюулгүй ажлын байрыг бий болгож, аюулгүй ажил, хөдөлмөрийг дэмжих үүрэгтэй бөгөөд ажлын байранд баг хамт олонтойгоо байнга нягт хамтран ажиллаж аюулгүй байдлыг байнга манлайлж, ажилтнууддаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг хэвшүүлсэн орчин нөхцөлийг бүрдүүлэхэд манлайлна.

6. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 “ЯНЧЕН ШИНГУО КОНСТРАКШН ИНЖЕНЕРИНГ ” ХХК-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай зөвлөлийн зорилго нь хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажлын таатай орчныг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад оршино.

6.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай орон тооны бус зөвлөл /цаашид “зөвлөл” гэнэ/-ийг ажил олгогчийн болон ажилтны төлөөлөөс томилсон гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулна.

6.3 Зөвлөлийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан ахлана.

6.4 Зөвлөлийн гишүүдийн тоо 3-9 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөл нь хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хууль, ХАБЭА-н чиглэлээр гарсан дүрэм, журмууд болон бусад хууль эрхийн актууд, энэ журмыг удирдлага болгон ажиллана.

6.5 Зөвлөл нь өөрийн чиг үүрэгтэй холбогдуулан шаардлага зөвлөмж гаргана. Зөвлөлөөс гаргасан шаардлага, зөвлөмжийг тухайн нэгж, байгууллагын холбогдох албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

6.6 Зөвлөлийн эрх:

6.6.1 Ажил олгогч болон салбар хэсэг нэгжийн албан тушаалтанд аюулгүй байдал хөдөлмөрийн тааламжтай нөхцөлийг буй болгох гарч болзошгүй осол эндэгдэл өвчлөлөөс сэргийлэх арга хэмжээ авах талаар шаардлага тавих;

- 6.6.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтан ажилтанд хариуцлага хүлээлгэх талаар ажил олгогчид санал тавих;
- 6.6.3 Байгууллагын хэмжээнд хөдөлмөрийн эрүүл аюулгүй нөхцөлийг бий болгох сайжруулахад идэвх санаачилгатай ажилласан хүмүүсийг урамшуулах санал оруулах;
- 6.7 Зөвлөлийн үүрэг:
- 6.7.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах;
- 6.7.2 Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр төлөвлөгөө, төсөвт тусгах асуудлыг боловсруулах, шаардлагатай дүрэм, журмыг баталж, мөрдүүлэхэд санал өгөх, хамтран ажиллах;
- 6.7.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан нөхцөлийн талаар хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах;
- 6.7.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах ажлыг ажил олгогчтой хамтран хийх;
- 6.7.5 Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийж, осолд дөхсөн тохиолдлыг илрүүлэхэд оролцох, бүртгэл судалгаатай танилцах, ажил олгогчоос шаардлагатай мэдээлэл гаргуулж авах;
- 6.7.6 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх, дүнг ажил олгогч, ажилтнуудад мэдээлэх;
- 6.7.7 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, хэрэглээ, ахуйн байрны орчин нөхцөл, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, түүний мөрөөр хийгдсэн эмчилгээ, сувилгаатай танилцах, хоолны чанарт хяналт тавих, үр дүнг мэдээлэх;
- 6.7.8 Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүдийг чадваржуулах арга хэмжээг ажил олгогчтой хамтран зохион байгуулах;
- 6.7.9 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлах сэрэмжлүүлэх хууль дүрэм журам стандартыг мөрдөх талаар нийт ажилтны үүрэг хариуцлагыг өндөржүүлэх хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх үйл ажиллагаанд оролцох
- 6.7.10 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажилтны гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэх талаар ажил олгогчид зөвлөмж, шаардлага өгөх;

7. ИРГЭН, АЖИЛТАН БОЛОН ГЭРЭЭТ КОМПАНИ, БРИГАДУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

- 7.1 Иргэн Ажилтан болон гэрээт компани болон бригадуудын эрх үүрэг.
- 7.2 Өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 7.3 Ажил эхэлхийн өмнө заавал талбайн инженер, хэсгийн инженер, бригадын дарга нараас тухайн өдрийн ажлын чиг үүргийг тодорхойлсон, ажилтаны ажил үүрэгт тохирсон аюулгүй ажиллагааны зааварчилгааг авч гарын үсэг зурж баталгаажуулсны дараа ажил эхлэнэ.
- 7.4 Шууд удирдлагаасаа аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй үед дур мэдэн ажил эхлэх мөн тухайн өдрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан ажлаас өөр ажил хийхийг хориглоно.

7.5 Төслийн талбай, ажлын байранд архи согтууруулах ундааны зүйл, хар тамхи болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл авч нэвтрэх болон хэрэглэхийг хатуу хориглоно.

7.6 Төслийн талбайд ажлын цагаар ажилтан ажлын байраа орхиж явах бол удирдах ажилтандаа заавал мэдэгдсэн байна.

7.7 Гэрээт компани болон, бригадууд өөрийн ажилчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, тусгай хувцасаар хангах үүрэгтэй бөгөөд ХАБЭА-н тухай хуулийн 28.4-р зүйл заалт болон Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх дүрмийн 1.7-д заасанчлан гэрээт үйл ажиллагаатай холбоотой аливаа зөрчил, осол, хурц хордлогыг зохих газар мэдээллэх үүрэгтэй бөгөөд өөрийн ажилтан, ажиллагсад, зочдыхоо аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

7.8 Ажил эхэлхээс өмнө захиалагч болон гэрээтээс уг төслийг удирдаж байгаа бүх инженер, техникийн ажилтанууд эрсдэлийн үнэлгээ хийх бөгөөд хөрсний нурулт, хэв цутгалт, барилгийн даацын өөрчлөлт, шатны аюулгүй байдал, агааржуулалт, тоосжилт, өндөрт болон хязгаарлагдмал орчинд ажиллах, суурин нүх, худгийн нүхрүү хүн унаж бэртэх, гадна усан хангамж ариутгах татуургын угсралт, гадна дулаан хангамжийн шугам сүлжээний угсралт, холбоо болон цахилгааны агаарын шугмыг зөөн шилжүүлэх ажлууд болон газар шорооны ажил, авто зам тавих ажил болон ачаа зөөж буулгах үеийн гарч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг аван, төслийн ажилд оролцох хүмүүст танилцуулна.

7.9 Тухай төсөлд хэрэгжиж буй талбайд захиалагч талын ХАБЭА-н бүх бодлого, дүрэм журам, хэрэгжих бөгөөд аливаа зөрчилд арга хэмжээ авах эрхийг захиалагч компаниас төслийг удирдаж байгаа албан тушаалтан болон ХАБЭА-н ажилтан эдлэнэ.

7.10 Машин, механизм нь мэргэжлийн байгууллагаар техникийн магадлагаа хийлгэж зохих зөвшөөрлийг авч техникийн бүрэн бүтэн байдал хангасан, засвар үйлчилгээ тохируулгыг техникийн баримт бичигт заасны дагуу хийгдсэн тохиолдолд төслийн талбайд оруулна.

7.11 Аюулгүй байдал хангаагүй эсвэл зөвшөөрөлгүй тоног төхөөрөмж машин механизмыг төслийн талбайд оруулахыг хориглоно.

7.12 Машин, механизм техник, тоног төхөөрөмжийг зөвхөн мэргэжлийн үнэмлэхтэй, томилогдсон ажилтан ажлуулна. Мэргэжлийн үнэмлэхгүй тухай ажилд томилогдоогүй ажилтан дур мэдэн машин механизм, тоног төхөөрөмжийг ажлуулахыг хориглоно.

7.13 Компаний Хөдөлмөрийн Аюулгүй байдал, Эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан нь ажлын байрны аюулгүй байдал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үйл ажиллагаануудыг Үл тохирол илрүүлэх, сайжруулах маягтын дагуу тогтмол хэрэгжүүлж ажиллана.

7.14 Компани химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодис, түүний нөлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

7.15 Компаний ажилчид учирч болзошгүй аюул, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдах үед ажил олгогчид яаралтай мэдэгдэх, өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх үүрэгтэй.

8. ХӨДӨЛМӨРИЙН АЯТАЙ НӨХЦӨЛӨӨР ХАНГУУЛАХ ИРГЭН, АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ

8.1 Ажил олгогч, ажилтан нар хөдөлмөрийн үйл ажиллагааны хуваарьт, ажлын график төлөвлөгөө, үйлдвэрлэл, сургалтын удирдамжийн хүрээнд өгөгдсөн ажил, үүргийг гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах.

8.2 Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан дараах эрхтэй байна:

- 8.2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах;
- 8.2.2 Ажлын байрны нөхцөл, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, түүнчлэн үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн талаар бодит мэдээлэл авах;
- 8.2.3 Ажил, үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдлын журам зөрчигдсөн болон амь нас, эрүүл мэндэд нь сөрөг, аюултай нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, энэ талаар ажил олгогчид мэдэгдэх;
- 8.3 Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан дараах нийтлэг үүрэгтэй байна:
- 8.3.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх;
- 8.3.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, хуульд тусгайлан заасан бол шалгалт өгсөн, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх;
- 8.3.3 Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах;
- 8.3.4 Эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орох;
- 8.3.5 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх;
- 8.3.6 Ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх;
- 8.3.7 Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх;
- 8.3.8 Ажил эхлэхийн өмнө тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг заавал шалгана.
- 8.3.9 Ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах;

9. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ЗААВАРЧИЛГАА

- 9.1 Ажил эхлэхийн өмнө ажилтнууд өгөгдсөн ажлын даалгавар, удирдамжийн дагуу хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилтан бригад бүрт өгч, журнал дээр гарын үсэг зуруулан өгсөн мэдээллийг дахин нягталж ажилд гарна.
- 9.2 Сургалтын тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай зааварчилгаа юм. Зааварчилгаа нь дараах төрөлтэй байна. Үүнд:
- 9.2.1 Урьдчилсан зааварчилгаа Байгууллагад шинээр ажилд орж байгаа ажилтанд тухайн ажлын байрны аюулгүй ажиллагааны дүрэм, зааварчилгаа, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, түүнийг ашиглах тогтмол хэрэглэж хэвшүүлэх, байгууллагын дотоод журам, ажлын байранд галын аюулгүй байдлыг хангах, аюулыг танин мэдэх, илрүүлэх, мэдээлэх, арилгах ажлын байранд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж зэрэг агуулгын хүрээнд ХАБЭА-н ажилтан чиглүүлэн удирдан явуулж, урьдчилсан зааварчилгааны бүртгэлд тэмдэглэнэ. Урьдчилсан зааварчилгааг өгсний дараа зааварчилгааны агуулгын хүрээнд шалгалт авах ба 80-аас дээш үнэлгээ авсан иргэнийг хяналтын хуудас бөглөж тухайн ажиллах хүсэлт гаргасан цех уруу нь шилжүүлнэ.

9.2.2 Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа Тухайн ажилтны ажлыг гүйцэтгэх процесс ба ажлын онцлог, аюулгүй ажиллагааны арга барилууд, ажлын хувцас, хамгаалах хэрэгслүүд зэрэг агуулгын хүрээнд нэгжийн удирдлага (салбар хэсгийн ахлах) нь өгч, анхан шатны зааварчилгааны дэвтэрт тэмдэглэн гарын үсэг зуруулна.

9.2.3 Давтан зааварчилгаа гэсэн төрөл ангилалтайгаар явагдана. Давтан зааварчилгааг ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор ажлын байран дахь анхан шатны зааварчилгааны агуулгаар өгнө.

9.2.3.1 Давтан зааварчилгаа нь 3 хэлбэртэй байна.

9.2.3.1.1 Ээлжит давтан зааварчилгаа Шинэ технологи, машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нэвтрүүлэх, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөх, ХАБЭА-н тухай дүрэм, заавар шинэчлэгдэж өөрчлөгдөх үед давтан зааварчилгааг алба, нэгжийн шууд удирдлага, ХАБЭА-н ажилтан өгч, давтан зааварчилгааны бүртгэлд тэмдэглэн гарын үсэг зуруулна.

9.2.3.1.2 Ээлжит бус давтан зааварчилгаа ХАБЭА-н дүрэм, зааврыг ноцтой зөрчсөн хүмүүс буюу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого гарсан салбар нэгж хэсгийн ажилтан нарт, мөн 1 сараас илүү хугацаагаар ажлаас хөндийрч яваад эргэж ажилдаа орсон ажилтанд ээлжит бус давтан зааварчилгааг алба, нэгжийн шууд удирдлага, ХАБЭА-н ажилтан өгч, давтан зааварчилгааны бүртгэлд тэмдэглэн гарын үсэг зуруулна.

9.2.3.1.3 Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа нь товч тодорхой байх ба ажил эхлэхийн өмнө бичгээр өгөгдөнө. Тухайн алба, нэгжийн шууд удирдлага (салбар, хэсгийн ахлах) зааварчилгааг ажилтанд танилцуулж, өдөр тутмын зааварчилгааны дэвтэрт тэмдэглэн ажилтнаар гарын үсэг зуруулна.

10. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ СУРГАЛТ

10.1 ХАБЭА-н тухай сургалт зохион байгуулах ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу ХАБЭА-н ажилтан хариуцан зохион байгуулах;

10.2 Нарийн мэргэжил аргазүй шаардсан сургалтыг тухайн сургалтыг зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах;

10.3 Сургалт зохион байгуулагдсан сургалтын талаарх тайлан мэдээг ХАБЭА-н ажилтан гаргаж нийт ажилтнууд болон удирдлагад тухай бүр тайлагнаж байх;

10.4 ХАБЭА-н тухай мэдээлэл, сурталчилгааг ажлын байрны орчинд тогтмол зохион байгуулах удирдах ажилтан болон ХАБЭА-н ажилтан гүйцэтгэж байх;

10.5 ХАБЭА-н тухай мэдээллийн самбар болон сурталчилгааны зурагт хуудсыг салбар нэгж хэсгүүдэд байршуулж мэдээллийг тогтмол шинэчилж байх;

11. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

11.1 Ажлын байр, ажилбарт үүсэж болзошгүй аюулыг тогтоож, эрсдэлийг үнэлэх, хяналт тогтоох, дахин сайжруулах, эрсдэлээс үүдэлтэй осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээг хийнэ.

- 11.2 Эрсдэлийн үнэлгээг дараах нөхцөлд хийнэ:
 - 11.2.1 Холбогдох хууль, эрх зүйн шаардлага өөрчлөгдсөн үед;
 - 11.2.2 Үйлдвэрлэлийн процесс, үйл ажиллагаа өөрчлөгдсөн үед;
 - 11.2.3 Шинэ ажлын байр, тоног төхөөрөмжийг ашиглаж эхлэхээс өмнө;
 - 11.2.4 Ажил гүйцэтгэх явцад шинээр аюул эрсдэл бий болсон үед;
